

Азийн Хөгжлийн Банк  
ба түүний зээлдэгч  
**Зөвлөхийг ашиглах**  
журам

2013 оны 3 дугаар сар

The logo of the Asian Development Bank (ADB) is a black square with the letters "ADB" in white, serif font.

Азийн Хөгжлийн Банк  
ба түүний зээлдэгч  
Зөвлөхийг ашиглах  
журам

2013 оны 3 дугаар сар

Asian Development Bank

© 2013 Азийн Хөгжлийн Банк

Бүх эрхийг хамгаалав. 2013 онд хэвлэн гаргав.  
Филиппин улсад хэвлэв.

ISBN 978-92-9254-149-1  
Хэвлэлийн агуулах дугаар. ТИМ135720-2

Хэвлэлийн мэдээллийн сан дахь каталогжуулалт

Азийн Хөгжлийн Банк.

Азийн Хөгжлийн Банк ба түүний зээлдэгч зөвлөхийг ашиглах журам  
Мандалуён хот, Филиппин улс: Азийн Хөгжлийн Банк, 2013.

1. Зөвлөх. I. Азийн Хөгжлийн Банк.

Азийн Хөгжлийн Банк  
6 АХБ-ны өргөн чөлөө, Мандалуён хот  
1550 Метро Манила, Филиппин улс  
Утас +63 2 632 4444  
Факс +63 2 636 2444  
[www.adb.org](http://www.adb.org)

Захиалахыг хүсвэл:  
Гадаад харилцааны газарт хандана уу  
Факс +63 2 636 2648  
[adbpub@adb.org](mailto:adbpub@adb.org)

Энэхүү баримт бичгийг илүү өргөн хүрээнд олон хэрэглэгчдэд хүргэх зорилгоор англи хэлнээс хөрвүүлэн орчуулав. Азийн Хөгжлийн Банк (АХБ) орчуулгын үнэн зөв, нягт нямбай байдлыг тодруулан ажиллаж ирсэн ба англи хэл нь АХБ-ны албан ёсны хэл мөн бөгөөд энэхүү баримт бичгийн англи хувь нь зөвхөн жинхэнэ (өөрөөр хэлбэл, албан ёсны бөгөөд баталгаат) эх бичмэл мөн болно. Бичмэлээс аливаа ишлэл татахдаа, энэхүү баримт бичгийн англи хувийг дурдах нь зүйтэй.

# Агуулга

## I. Оршил ба баримтлах бодлого

1.1	Зорилго	1
1.4	Нийтлэг үндэслэл	2
1.7	Хамрах хүрээ	3
1.10	Сонирхлын зөрчил	4
1.12	Шударга бус өрсөлдөөний давуу эрх	6
1.13	Оролцох эрх	6
1.14	Зөвлөхүүд хамтран нэгдэх	7
1.15	Урьдчилан гэрээ байгуулах, нөхөн санхүүжүүлэх	8
1.16	АХБ-ын хяналт, туслалцаа, хяналт шинжилгээ	8
1.18	Зүй бус худалдан авах ажиллагаа	9
1.19	АХБ-ыг дурдах	9
1.20	Чадавхийг хөгжүүлэх	10
1.21	Сургалт явуулах буюу мэдлэг шилжүүлэх	10
1.22	Хэл	10
1.23	Залилан ба авлига	11
1.26	Гүйцэтгэлийн үнэлгээ	13
1.27	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө	13

## II. Сонгон шалгаруулах горим

<b>A.</b>	<b>Сонгон шалгаруулалтын арга</b>	<b>14</b>
2.1	Зөвлөх компанийг авч ажиллуулах	14
2.2	Чанар ба үнэд суурилсан сонгон шалгаруулалт	14
2.23	Чанарт суурилсан сонгон шалгаруулалт	20
2.26	Тогтмол төсвийн сонгон шалгаруулалт	21
2.27	Бага үнийн сонгон шалгаруулалт	21
2.28	Зөвлөхийн чадварын сонгон шалгаруулалт	22
2.29	Нэг эх үүсвэрээс сонгон шалгаруулах	22
2.33	Арилжааны практик арга	24
2.34	Зөвлөх хувь хүнийг авч ажиллуулах	24
2.35	Тусгай зөвлөхийг авч ажиллуулах	24
2.35	Зөвлөх ажилтан	24
2.36	Нөөц ажилтан	25
2.37	НҮБ ба бусад мэргэшсэн байгууллагууд	25
2.38	Төрийн бус байгууллага (ТөББ)	25

2.39	Худалдан авах ажиллагааны төлөөлөгч (ХТ)	26
2.40	Хянан шалгах төлөөлөгч	26
2.41	Банк	27
2.42	Аудитын компани	27
2.43	Үйлчилгээ үзүүлэх ажил	27
<b>Б.</b>	<b>Гэрээлэх арга</b>	<b>28</b>
2.45	Хугацааны гэрээ	28
2.46	Үндсэн цалин ба/эсвэл магадлашгүй ажлын (үр дүнгийн) хөлсний гэрээ	28
2.47	Хугацаа нь товлогдоогүй үйлчилгээний гэрээ (Үнийн тохиролцоо)	28
2.48	Нийт үнийн (НҮ) гэрээ	29
2.49	Гүйцэтгэлд суурилсан гэрээ	29
<b>В.</b>	<b>Зээлийн зөвлөхийн гэрээний чухал заалтууд</b>	<b>29</b>
2.51	Мөнгөн тэмдэгт	30
2.52	Үнийн тохируулга	30
2.53	Төлбөрийн заалт	30
2.55	Урьдчилгаа төлбөрийн баталгаа	31
2.56	Зээлдэгчийн хувь нэмэр	31
2.57	Сонирхлын зөрчил	31
2.58	Мэргэжлийн хариуцлага	32
2.59	Мэргэжилтнийг солих	32
2.60	Мөрдөх хууль ба маргааныг шийдвэрлэх	32
<b>Г.</b>	<b>Хяналт тавих ба гүйцэтгэлийг үнэлэх</b>	<b>32</b>
2.61	Сонгон шалгаруулах явцыг хянах	32
2.62	Гүйцэтгэлийн үнэлгээ	33
	<b>Хавсралтууд</b>	
1 дүгээр хавсралт	ЧҮСС ба ЧСС-ын горимын хураангуй дүгнэлт	34
2 дугаар хавсралт	Зээлийн төслийн зөвлөхөд зориулсан зөвлөмж	36

# I. Оршил ба баримтлах бодлого

## Зорилго

1.1 Энэхүү журмын зорилго нь Азийн Хөгжлийн Банк (АХБ)-наас олгосон аливаа зээл, буцалтгүй тусламж, эсхүл АХБ-наас захиран зарцуулдаг сангаас бүрэн ба хэсэгчлэн санхүүждэг зээлийн болон техник тусалцаа (ТТ)-ны төслийн зөвлөхийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, түүнд хяналт шинжилгээ хийх үед дагаж мөрдөх АХБ-ны бодлого, горим журмыг тодорхойлоход оршино. Уг журам нь АХБ-ны баримтлах бодлого, горим журмыг илэрхийлэх ба нэмэлт тодруулгыг АХБ-ны төслийн удирдлагын заавар (ТУЗ),<sup>1</sup> ба/эсхүл зөвлөх үйлчилгээний тендерийн жишиг баримт бичиг (ТББ)<sup>2</sup>-т тусган оруулав.

1.2 Зээлийн гэрээ, буцалтгүй тусламжийн гэрээ болон ТТ-ны гэрээ<sup>3</sup> нь АХБ ба төсөл хүлээн авагчийн хооронд эрх зүйн харилцааг зохицуулах ба эдгээр гэрээнд дурдсаны дагуу зөвлөхийг сонгон шалгаруулахдаа энэ журмыг дагаж мөрдөнө. Зээлдэгч,<sup>4</sup> эсхүл АХБ, ба зөвлөхийн эрх үүрэг нь энэхүү журам, зээлийн гэрээ, буцалтгүй тусламжийн гэрээ болон ТТ-ны гэрээгээр бус, харин зөвхөн зээлдэгч эсвэл АХБ-наас гаргасан ТББ, зээлдэгч, эсвэл АХБ ба зөвлөхийн хооронд гарын үсэг зурагдсан гэрээгээр

---

<sup>1</sup> ТУЗ-ыг АХБ-ны [www.adb.org](http://www.adb.org) вэб хуудаснаас үзэж болно.

<sup>2</sup> Зээлийн төсөлд хэрэглэгддэг тендерийн баримт бичгийг бусад олон талт хөгжлийн банкны баримт бичигтэй бүрэн хэмжээгээр нийцүүлсэн ба энэ талаар АХБ-ны [www.adb.org](http://www.adb.org) вэб хуудаснаас үзэж болно.

<sup>3</sup> АХБ-ны санхүүжилттэй ТТ-ны хүрээнд хүлээн авагч улс нь АХБ-тай ТТ-ны ерөнхий хэлэлцээрт байгуулах бөгөөд ерөнхийдөө ТТ-ны бүх төсөлд АХБ ба хүлээн авагч улсын харилцааг зохицуулна. ТТ-ны төсөл бүрийн хувьд, ТТ-ны гэрээг АХБ ба зээлдэгчийн хооронд хэлэлцэн байгуулна. ТТ-ны гэрээнд ТТ-ны ерөнхий хэлэлцээр болон ТТ-г батлахад бэлтгэсэн ТТ-ны баримт бичгийн нөхцөл, заалтуудыг тусгаж оруулна.

<sup>4</sup> Зээлдэгч эсхүл буцалтгүй тусламжийг хүлээн авагч өөрөөр шууд төслийг хэрэгжүүлээгүй тохиолдолд энэхүү журамд заасан "зээлдэгч" гэсэн нэр томъёонд АХБ-ны санхүүжилттэй төслийг хариуцаж буй гүйцэтгэгч ба/ эсвэл хэрэгжүүлэгч агентлагууд багтана.

зохицуулагдана. Зээлийн гэрээ, буцалтгүй тусламжийн гэрээ болон ТТ-ны гэрээг байгуулсан талуудаас өөр ямар ч тал гэрээний эрх эдлэх, эсвэл зээл, буцалтгүй тусламж, ТТ-ны хөрөнгийг нэхэмжлэх эрхгүй болно.

1.3 Энэхүү журамд зөвлөхүүд гэсэн нэр томъёонд хувийн ба төрийн өмчит байгууллагууд, тухайлбал олон улсын<sup>5</sup> ба дотоодын<sup>6</sup> зөвлөх компани, инженерийн компани, барилгын компани, менежментийн компани, худалдан авах ажиллагааны мэргэшсэн байгууллага, хяналт шалгалтын байгууллага, аудитын компани, Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын харьяа байгууллага, бусад олон талт хамтын ажиллагааны байгууллага, их сургууль, судалгааны газар, төрийн ба төрийн бус байгууллагууд (ТөББ) болон хувь хүмүүсийг<sup>7</sup> хамруулан ойлгоно. Зээлдэгч эсвэл АХБ-ны чадавхийг дээшлүүлэх үүднээс бодлогын зөвлөгөө, байгууллагын шинэтгэл, менежмент, инженерийн ажил, барилгын ажлын хяналт, санхүү, худалдан авах ажиллагаа, нийгэм ба байгаль орчны судалгаа зэрэг өргөн хүрээтэй үйл ажиллагаанд туслуулах, мөн дээрх чиглэлээр төсөл тодорхойлох, бэлтгэх, хэрэгжүүлэхийн тулд АХБ, түүний зээлдэгч эдгээр байгууллагыг зөвлөхөөр авч ажиллуулахад ашиглана.

## Нийтлэг үндэслэл

1.4 Зээлдэгч нь ерөнхийдөө зээлээр санхүүжүүлэх зөвлөхийг<sup>8</sup> сонгон шалгаруулах, ажилд авах, тэдэнд хяналт тавих үүрэг хүлээдэг бол АХБ нь ТТ-ны буцалтгүй тусламжийн хүрээнд санхүүжүүлэх зөвлөхийг<sup>9</sup> сонгон шалгаруулах, ажилд авах, тэдэнд тавих хяналтыг хариуцна. Зөвлөхийг ажилд авахад баримтлах дүрэм, горим журам тухайн нөхцөл байдлаас шалтгаалдаг хэдий ч зөвлөх сонгон шалгаруулах АХБ-ны бодлогод дараах үндсэн зургаан үндэслэлийг авч хэрэглэнэ:

- (а) Өндөр чанартай үйлчилгээ үзүүлэх шаардлага,
- (б) Хэмнэлт, үр ашигтай байх шаардлага,

<sup>5</sup> “Олон улсын зөвлөх” гэдэг нь аливаа эрх бүхий улс, түүний дотор зээлдэгч улсад үүсгэн байгуулагдсан эсхүл бүртгэгдсэн зөвлөх компани эсхүл аливаа эрх бүхий улс, түүний дотор зээлдэгч улсын иргэн хувь хүнийг хэлнэ.

<sup>6</sup> “Дотоодын зөвлөх” гэдэг нь зээлдэгч улсад байгуулагдсан эсхүл бүртгэгдсэн зөвлөх компани эсвэл зээлдэгч улсын иргэн хувь хүнийг хэлнэ.

<sup>7</sup> Зөвлөх хувь хүний талаар 2.34 дүгээр зүйлийг үзэх.

<sup>8</sup> Азийн хөгжлийн сан (АХС)-гийн буцалтгүй тусламжаас бүрэн ба хэсэгчилэн санхүүждэг хөрөнгө оруулалтын төслийн хүрээнд авч ажиллуулсан зөвлөхүүд багтана.

<sup>9</sup> ТТ-ны төслийг эзэмших эрхийг нэмэгдүүлэх, төслийн үр өгөөжийн тогтвортой байдлыг сайжруулахыг тулд тодорхой нөхцөлд АХБ зээлдэгчид ТТ-ны зөвлөхийг авч ажиллуулах, хянах үүрэг хариуцлагыг шилжүүлж болно (“шилжүүлсэн ТТ”).

- (в) Бүх мэргэшсэн зөвлөхүүдэд АХБ-ны санхүүжилттэй зөвлөх үйлчилгээнд өрсөлдөх боломжийг олгох шаардлага,
- (г) Хөгжиж буй гишүүн орон (ХГО)-ны дотоодын зөвлөхийг хөгжүүлэх, авч ажиллуулахыг дэмжих АХБ-ны сонирхол,
- (д) Сонгон шалгаруулах ажиллагаанд ил тод байдлыг хангах шаардлага,
- (е) Авлигатай тэмцэх, ёс зүйн хэм хэмжээг сахихад анхаарлаа дээшлүүлэх шаардлага.

1.5 Ихэнх тохиолдолд саналын чанар, шаардлагатай бол үйлчилгээний үнэ өртөгт тулгуурлан сонгон шалгаруулж, хураангуй жагсаалтад орсон компаниудыг өөр хооронд нь өрсөлдүүлэх байдлаар дээрх үндэслэлийг хангах боломжтой гэж АХБ үздэг. Энэ журмын 2 дугаар бүлгийн А хэсэгт, АХБ-наас хүлээн зөвшөөрөгдсөн, зөвлөхийг шалгаруулах төрөл бүрийн аргууд, тэдгээрийг хэрэглэх зохистой нөхцөл байдлын талаар өгүүлэв. Чанар ба үнэд суурилсан сонгон шалгаруулалт (ЧҮСС) нь хамгийн түгээмэл арга байх ба журмын 2.2–2.21 дүгээр зүйлд ЧҮСС-ын горим дүрмийн талаар дэлгэрэнгүйгээр тайлбарлана. ЧҮСС нь хэрэглэхэд хамгийн тохиромжтой арга нь биш тохиолдолд бусад аргын талаар 2.23–2.32 дугаар зүйлд өгүүлсэн болно.

1.6 Зээлийн ба ТТ-ны төслийн зөвлөхийг сонгон шалгаруулахад хэрэглэх аргыг зээлийн гэрээ, буцалтгүй тусламжийн гэрээ болон ТТ-ны гэрээнд дурдана. Төслийн хүрээнд санхүүжигдэх тодорхой гэрээнүүд, түүнчлэн зээл, буцалтгүй тусламж болон ТТ-ны гэрээнд заасан сонгон шалгаруулах аргыг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгана (1.27 дугаар зүйлийг харах).

## Хамрах хүрээ

1.7 Уг журамд заасан зөвлөх үйлчилгээ гэдэгт улсын ба хувийн хэвшлийн олон салбарт, төслийн бүх үе шатны янз бүрийн үйлчилгээг<sup>10</sup> хамарсан оюуны болон зөвлөхийн шинж чанартай үйлчилгээг хамруулж ойлгоно. Энэхүү журмыг биет хэлбэр давамгайлсан бусад төрлийн үйлчилгээ (барилгын ажил гэх мэт)-нд хэрэглэхгүй.

---

<sup>10</sup> “Үйлчилгээ” гэдэгт бодлогын зөвлөгөө; засаглал; бүтцийн өөрчлөлт; ядуурлыг бууруулах ба жендерийн асуудал зэрэг нийгмийн асуудлууд; байгаль орчны үнэлгээ ба аудит хийх, оролцоогоор хангах ба зөвлөлдөх, бүтцийг бэхжүүлэх ба сургалт зэрэг чадавхийг бэхжүүлэх; эрх зүйн ба санхүүгийн үйлчилгээ; удирдлага ба инженерийн үйлчилгээ; болон барилгын ажлын хяналт зэрэг орно.



1.8 АХБ ба зээлдэгчээс хэрэгжүүлэх зээл, ТТ, эсвэл бусад буцалтгүй тусламж ба АХБ-наас захиран зарцуулдаг сангаас бүрэн болон хэсэгчлэн санхүүжүүлэх зөвлөх үйлчилгээний бүх төрлийн гэрээнд энэхүү журмыг дагаж мөрдөнө. Үүнээс бусад санхүүжилтийн эх үүсвэрээр зөвлөх үйлчилгээг сонгон шалгаруулах тохиолдолд зээлдэгч өөр журмыг ашиглаж болно. Энэ тохиолдолд, АХБ (i) мөрдөж хэрэглэх журам нь шаардлагатай мэргэжлийн чадвартай зөвлөхийг сонгон шалгаруулахуйц байх, (ii) сонгон шалгарсан зөвлөх тохирсон хуваарийн дагуу даалгаврыг гүйцэтгэх, (iii) зөвлөх үйлчилгээний цар хүрээ нь төслийн хэрэгцээнд нийцсэн байх зэрэг нөхцлийг хангасан байхыг шаардана.

1.9 Зээлдэгч нь зөвлөхийг зээлийн төсөл ба шилжүүлсэн ТТ-ны хүрээнд үйлчилгээ үзүүлэх компани, хувь хүнээс сонгон шалгаруулна. АХБ-ны өөрийн эх үүсвэрээс санхүүжилттэй, эсхүл бусад эх үүсвэрээс санхүүжилттэй хэдий ч, бусад санхүүжүүлэгч байгууллагын нэрийн өмнөөс АХБ-наас хэрэгжүүлж буй ТТ-ны төсөлд АХБ нь зөвлөхүүдийг ашиглана. Түүнчлэн, АХБ (i) АХБ-ны захиргааны төсвийн санхүүжилттэй гэрээний хүрээнд АХБ-ны үйл ажиллагааг мэргэжлийн тусгай мэдлэг, зөвлөгөөгөөр хангах замаар, өөрийн боловсон хүчнийг нөхөхийн тулд зөвлөх ажилтныг, (ii) хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулахын тулд нөөц хүнийг тус тус авч ажиллуулдаг. Энэ тохиолдолд зөвлөхийг АХБ сонгон шалгаруулна. Зөвлөхийн үүргийг ажлын даалгавар (АД)-т тодорхойлж өгөх ба ТТ-ны төслийн хувьд хүлээн авагч байгууллагатай хамт бэлтгэж боловсруулна.

## **Сонирхлын зөрчил**

1.10 Аливаа тал албан үүрэг хариуцлага, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, эсвэл хууль тогтоомж мөрдөхөд нь аль нэг тал зүй бусаар нөлөөлөх сонирхолтой, бөгөөд тэрхүү сонирхлын зөрчил нь АХБ-ны авлигын эсрэг бодлогод хориглосон үйл ажиллагааг бүрдүүлэхэд нөлөөлсөн, эсхүл бүрдүүлсэн бол түүнийг АХБ сонирхлын зөрчил гэж үзнэ. Авлигын эсрэг бодлогод шаардсаны дагуу зээлдэгч (АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагааны үр шим хүртэгчийг оруулан) болон АХБ-ны санхүүжилттэй гэрээний зөвлөх ёс зүйн өндөр хэм хэмжээг сахих ёстой тул, хэрэв сонирхлын зөрчлийн улмаас аливаа зөвлөхийг сонгон шалгаруулах ажиллагаа шударга бус явагдсан гэж АХБ үзвэл уг сонирхлын зөрчлийг зохицуулах арга хэмжээг авах, эсвэл гэрээ байгуулах эрх олгохоос татгалзаж болно.

1.11 Дээрх зүйлийн ерөнхий заалтаар хязгаарлахгүйгээр дор дурдсан нөхцөлд зөвлөх авч ажиллуулж үл болно:

- a) **Зөвлөхийн үйл ажиллагаа ба бараа, ажил, үйлчилгээ (энэ журамд заасан зөвлөх үйлчилгээнээс бусад) худалдан авах ажиллагааны хоорондын зөрчил.**<sup>11</sup> Төсөлд шаардагдах бараа, ажил, үйлчилгээ (энэ журамд заасан зөвлөх үйлчилгээнээс бусад)-г нийлүүлэхийн тулд АХБ эсхүл зээлдэгчээс авч ажиллуулсан зөвлөх компани, зөвлөх хувь хүн тухайн бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой зөвлөх үйлчилгээ үзүүлэх эрхгүй болно. Мөн эсрэгээр, төслийг бэлтгэх, хэрэгжүүлэх зөвлөх үйлчилгээ үзүүлэхээр ажилласан зөвлөх компани, зөвлөх хувь хүн тийнхүү боловсруулсан, эсхүл хэрэгжүүлсэн төслөөс үүдэн гарсан, эсвэл түүнтэй шууд холбоотой бараа, ажил, үйлчилгээ (энэ журамд заасан зөвлөх үйлчилгээнээс бусад)-г үзүүлэх эрхгүй болно.
- b) **Зөвлөх ажлууд хоорондын зөрчил.** Зөвлөх компани эсхүл зөвлөх хувь хүний өөр ажилтай нь шинж агуулгын хувьд зөрчилдөхөөр байвал, тухайн зөвлөх компани эсхүл зөвлөх хувь хүнийг аливаа ажилд шалгаруулж авахгүй. Жишээлбэл, дэд бүтцийн төслийн инженерийн дизайн боловсруулах ажлын зөвлөх компани, зөвлөх хувь хүнийг уг төслийн байгаль орчны нөлөөллийн хөндлөнгийн үнэлгээний ажилд авч ажиллуулахгүй. Мөн нийтийн өмчийн хувьчлалын асуудлаар захиалагчид туслалцаа үзүүлж буй зөвлөх компани эсхүл зөвлөх хувь хүн тухайн нийтийн өмчийг худалдан авах эрхгүй, худалдан авагч байгууллагад зөвлөгөө өгөх эрхгүй болно. Үүнтэй нэгэн адил, АД боловсруулсан зөвлөхийг уг ажлын гүйцэтгэгчээр шалгаруулж авахгүй.
- в) **Зээлдэгчийн ажилтнуудтай харилцаатай байх.** (i) Гэрээний АД-ыг боловсруулах, (ii) гэрээг сонгон шалгаруулах, эсвэл (iii) гэрээнд хяналт тавих зэрэгт шууд ба шууд бусаар оролцдог АХБ-ны ажилтан, эсвэл зээлдэгчийн ажилтантай бизнесийн, эсвэл гэр бүлийн харилцаатай бол, түүнчлэн энэ харилцаанаас үүдэн гарах зөрчлийг сонгон шалгаруулалт болон гэрээний хэрэгжилтийн үед АХБ-ны шаардлагад хүлээн зөвшөөрөхүйцээр шийдвэрлэж чадаагүй бол зөвлөх компани, зөвлөх хувь хүнд гэрээний эрх олгохгүй.

---

<sup>11</sup> Энэ журмын 1.7 дугаар зүйлийг үзэх.

## Шударга бус өрсөлдөөний давуу эрх

1.12 Сонгон шалгаруулалтын явцад шударга, ил тод байдлыг хангах үүднээс аливаа нэг ажлыг гүйцэтгэхээр өрсөлдөж буй зөвлөх компани эсхүл зөвлөх хувь хүн тухайн ажилтай холбогдолтой зөвлөх үйлчилгээг өмнө нь үзүүлж байснаараа өрсөлдөөний давуу эрхийг эдлэх ёсгүй. Иймд хураангуй жагсаалтад орсон бүх зөвлөхөд өрсөлдөх боломж олгох үүднээс АХБ, эсхүл зээлдэгч бүх мэдээллийг ТББ-ийн хамт явуулна.

## Оролцох эрх

1.13 Захирлуудын зөвлөл өөрөөр тодорхойлоогүй бол (i) санхүүжилтийн эх үүсвэрийг гаргаж буй хөгжингүй орны, эсвэл хөгжиж байгаа гишүүн орны зөвлөхүүд зээл эсхүл тусгай сангийн буцалтгүй тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх зөвлөх үйлчилгээг үзүүлэх, ба (ii) АХБ-ны гишүүн орны зөвлөхүүд зээл, эсвэл АХБ-ны энгийн хөрөнгийн эх үүсвэрийн болон АХБ-ны захиран зарцуулдаг сангийн буцалтгүй тусламжаас санхүүждэг зөвлөх үйлчилгээг үзүүлнэ. Тендерт оролцох нөхцөл нь гэрээт ажлыг гүйцэтгэх компанийн чадвараар хязгаарлагдана. Гэхдээ, дараах зүйлсийг бас харгалзан авч үзвэл зохино.

- а) НҮБ-ын дүрмийн 7-р бүлгийн дагуу НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн шийдвэрт нийцүүлэх үүднээс зээлдэгч орон аливаа орон, хувь хүн, хуулийн этгээдэд төлбөр хийхийг хориглосон тохиолдолд уг зөвлөхийг хасч болно. Зээлдэгч орон ийм шалтгаанаар зөвлөхийн, эсвэл барааны төлбөр хийхийг хориглосон бол тэр зөвлөхийг сонгон шалгаруулалтаас хасч болно.
- б) Зээлдэгч орны төрийн өмчийн үйлдвэрийн газар, байгууллага (i) эрх зүй, санхүүгийн хувьд бие даасан, (ii) арилжааны хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг, бөгөөд (iii) зээлдэгч, дэд зээлдэгчийн байгууллагаас хараат бус гэдгийг нотолж чадвал оролцож болно.
- в) Дээр дурдсан (ii) заалтанд хамаарахгүйгээр, зээлдэгч орны төрийн өмчит их дээд сургууль, эрдэм шинжилгээ, судалгааны байгууллага нь онцгой, ховор шинжтэй үйлчилгээ үзүүлдэг бөгөөд төслийг хэрэгжүүлэхэд тэдний оролцоо нэн шаардлагатай бол АХБ эдгээр байгууллагыг авч ажиллуулах асуудлыг тухайн нөхцөл бүрт тусгайлан авч үзсэний үндсэн дээр зөвшөөрч болно. Үүнтэй адил үндэслэлээр, их, дээд сургуулийн профессор, эрдэм шинжилгээ,

судалгааны байгууллагын эрдэм шинжилгээний ажилтнууд АХБ-ны санхүүжилтээр бие даан гэрээ байгуулж болно.

- г) Төрийн албан хаагч, төсвийн байгууллагын ажилтан нь зөвхөн (i) үндсэн ажлаасаа цалингүй чөлөөтэй байгаа, (ii) чөлөө авахаас өмнө ажиллаж байсан байгууллага тэднийг зөвлөхөөр авч ажиллуулаагүй байх, болон (iii) тэднийг авч ажиллуулснаар сонирхлын зөрчил үүсэхгүй байх (1.10 дугаар зүйлийг харах) шаардлагыг хангасан тохиолдолд хувь хүн эсвэл зөвлөх компанийн багийн гишүүн хэлбэрээр зөвлөхийн гэрээний дагуу ажиллаж болно.
- д) Энэ журмын 1.23 дугаар зүйлийн (г) дэд зүйл, мөн АХБ-ны авлигын эсрэг бодлого, шударга байдлын зарчим ба холбогдох журам (тухай бүрдээ шинэчлэгдэж байдаг)-ын дагуу хориглогдсон компани, хувь хүн АХБ-наас тогтоосон хугацаанд АХБ-наас санхүүждэг, эсвэл АХБ-наас захиран зарцуулдаг гэрээний эрх авах эрхгүй, эсвэл энэ гэрээнээс санхүүжилт авах эрхгүй байх болно.

## Зөвлөхүүд хамтран нэгдэх

1.14 Зөвлөхүүд өөрийн мэдлэг туршлагын хүрээг өргөжүүлэх, саналын техникийн шаардлагыг сайжруулах, ажилтны нөөцөө нэмэгдүүлэх, илүү сайн арга зүй, аргачлалаар хангах, зарим тохиолдолд илүү хямд үнийг санал болгох зорилгоор түншлэл,<sup>12</sup> эсвэл туслан гүйцэтгэх гэрээний хэлбэрээр өөр хоорондоо хамтран нэгдэж болно. Ийм байдлаар хамтрах нь урт хугацааны (тухайн ажлаас үл хамааран), эсвэл тодорхой төсөлд зориулсан байж болно. Хэрэв АХБ эсхүл зээлдэгч зөвлөхийг түншлэлийн хэлбэрээр авч ажиллуулах бол түншлэл аль нэг компанийг түншлэлийн төлөөлөөр томилох бөгөөд түншлэлийн бүх гишүүд гэрээнд гарын үсэг зурч, бүх ажлыг хамтдаа болон тус бүрдээ хариуцана. Зээлдэгч нь зөвлөхийг аливаа нэг компани эсвэл бүлэг компаниудтай хамтарч нэгдэхийг шаардах эрхгүй, гэхдээ дотоодын чадварлаг компанитай хамтрахыг дэмжиж болно.

<sup>12</sup> Хураангуй жагсаалтыг гаргах зорилгоор түншлэлийн улсыг түншлэлийг төлөөлөх компанийн улсаар тодорхойлно.

## Урьдчилан гэрээ байгуулах, нөхөн санхүүжүүлэх

1.15 Тохиромжтой үед, төслийн хэрэгжилтийг түргэтгэх зорилгоор гэрээг урьдчилан байгуулан, дараа нь санхүүжилт олгохыг АХБ дэмждэг. АХБ-ны зөвшөөрлийн дагуу зээлдэгч нь зээлийн гэрээнд гарын үсэг зурагдахаас өмнө, (хэдий зөвлөхийн гэрээ байгуулахгүй ч гэсэн) сонгон шалгаруулах ажлыг хийж болно. Энэ тохиолдолд, сонгон шалгаруулах ажиллагааг энэхүү журмын дагуу явуулах бөгөөд АХБ зээлдэгчийн сонгон шалгаруулах ажиллагааг хянана. Зээлдэгч гэрээг урьдчилан байгуулахтай холбоотой бүх эрсдэлийг өөрөө хариуцах бөгөөд сонгон шалгаруулах ажиллагаа, баримт бичиг болон гэрээ байгуулах эрх олгох санал зэрэгт АХБ-наас олгосон зөвшөөрөл нь тухайн төслийг заавал АХБ-ны зээлээр санхүүжүүлэх үндэслэл болохгүй. Хэрэв зөвлөхийн гэрээнд гарын үсэг зурсан бол зээлийн хэлэлцээрт гарын үсэг зурахаас өмнө уг гэрээний хүрээнд зээлдэгчээс хийсэн аливаа төлбөрийг АХБ-наас нөхөн төлөхийг нөхөн санхүүжүүлэлт гэж нэрлэх бөгөөд түүний хэмжээ зөвхөн зээлийн хэлэлцээрт дурдсан хязгаарт зөвшөөрөгдөнө. Тодорхой нөхцөлд, урьдчилан сонгон шалгаруулалтыг АХБ-ны ТТ, эсхүл шилжүүлсэн ТТ-ны төслийн хүрээнд гүйцэтгэж болно.

### АХБ-ын хяналт, туслалцаа, хяналт шинжилгээ

1.16 Энэ журмыг зээлдэгч мөрдөж байгаа эсэхийг баталгаажуулах үүднээс зээлийн болон шилжүүлсэн ТТ-ны зөвлөхийг авч ажиллуулахын өмнө АХБ-наас урьдчилсан хяналт тавьдаг. АХБ ийнхүү урьдчилан хянахдаа сонгон шалгаруулалтын бүх аргаар зөвлөхийг авч ажиллуулах янз бүрийн шатанд АХБ руу материалаа явуулан зөвшөөрөл авахыг зээлдэгчээс хүснэ. Урьдчилан хянах давтамж, цар хүрээ нь зээлдэгчийн чадавхиас хамаарна. Чадавхи, туршлага сайтай зээлдэгчээс цөөн материал шаардагдана. Зарим тохиолдолд урьдчилан хянахгүйгээр, дараа хянах тохиолдол бий. АХБ ба зээлдэгч нь урьдчилан хянах шаардлага, давтамж, цар хүрээ, мөн дараа хянах босгыг төсөл бэлтгэж байх явцад харилцан тохиролцож, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгана (1.6 ба 1.27 дугаар зүйлийг үзэх).

1.17 Онцгой нөхцөл байдалд, тухайлбал, сонгон шалгаруулалтанд оролцох сонирхолоо сонирхолоо илэрхийлэх хүсэлт (СИХ)-ийн тоо хангалтгүй, эсвэл зээлдэгчээс АХБ-д бичгээр хүсэлт гаргасан бол тухайн ажлыг хийх чадвартай гэж үзсэн компаниудын дэлгэрэнгүй жагсаалтыг АХБ зээлдэгчид гаргаж өгнө. Уг жагсаалтыг олгосноор эдгээр зөвлөхийг зөвшөөрснийг

илэрхийлэхгүй. Зээлдэгч жагсаалтаас зөвлөхийг хасах, хүсвэл өөр зөвлөхийг нэмж оруулж болох ба зээлдэгч ТББ-ийг тараахын өмнө эцсийн хураангуй жагсаалтыг АХБ-аар батлуулахаар хүргүүлнэ. Тохиромжтой бол, АХБ нь зээлдэгч ба зөвлөхийн уулзалтанд оролцож, шаардлагатай гэж үзвэл ажилтай холбоотой асуудлыг хөндөн зээлдэгчид тусалж болно.

## Зүй бус худалдан авах ажиллагаа

1.18 Холбогдох хэлэлцээрийн заалт ба энэ журмын дагуу зөвлөхийг сонгон шалгаруулаагүй бол АХБ зөвлөх үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхгүй. Тохиролцсон ёсоор сонгон шалгаруулалтыг явуулаагүй тохиолдолд АХБ түүнийг зүй бус худалдан авах ажиллагаа гэж зарлах бөгөөд, ихэнхдээ зүй бусаар худалдан авсан үйлчилгээнд хуваарилсан санхүүжилтийн хэсгийг хүчингүй болгодог. Зүй бус худалдан авах ажиллагаа гэж зарласны дараа АХБ зарим тохиолдолд ТББ-ийг дахин гаргахыг зөвшөөрч болно. Түүнээс гадна, АХБ холбогдох гэрээнд заагдсан бусад алдаа дутагдлыг засуулах арга хэмжээ авч болно. Хэдийгээр тухайн гэрээ нь АХБ-аас зөвшөөрөл авсны дагуу гарын үсэг зурагдсан байсан хэдий ч, АХБ-ны зөвшөөрлийг буруу ташаа мэдээлэлд тулгуурлан олгосон, эсвэл гэрээний нөхцлийг АХБ-ны зөвшөөрөлгүйгээр өөрчилсөн гэж үзвэл, АХБ зүй бус худалдан авах ажиллагаа хэмээн зарлах эрхтэй болно.

## АХБ-ыг дурдах

1.19 Төслийг АХБ-наас бүрэн, эсхүл хэсэгчлэн санхүүжүүлж байгаа тохиолдолд ТББ, гэрээний баримт бичигт АХБ-ыг дараах байдлаар дурдана.

".....[зээлдэгчийн нэр]..... [төслийн нэр]-ийн зардлыг санхүүжүүлэх зорилгоор Азийн Хөгжлийн Банкны [энгийн хөрөнгийн эх үүсвэр эсхүл тусгай сангийн эх үүсвэр]-ээс [зээл] [ба эсхүл буцалтгүй тусламж]-ийг авсан ба энэ гэрээний эрх бүхий төлбөрт [зээл] [буцалтгүй тусламж]-ийн хөрөнгийн хэсгийг ашиглах болно. Гэрээний нөхцөл (гэрээ) ба Азийн Хөгжлийн Банкнаас хийх төлбөр нь [зээл/буцалтгүй тусламжийн хэлэлцээр]-ийн холбогдох нөхцөл, *Азийн Хөгжлийн Банк, түүний зээлдэгч Зөвлөхийг ашиглах журмаар* зохицуулагдана. АХБ өөрөөр тусгайлан заагаагүй бол [зээлдэгчийн нэр]-ээс бусад ямар ч этгээд [зээл/буцалтгүй тусламжийн хэлэлцээр]-т заасан эрх эдлэх, эсвэл [зээл/буцалтгүй тусламж]-ийн санхүүжилтээс нэхэмжлэх эрхгүй болно."

## Чадавхийг хөгжүүлэх

1.20 АХБ дараах хэлбэрээр чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ. Үүнд: (i) ХГО-д зөвлөх сонгон шалгаруулах чадавхийг бэхжүүлэх хэрэгцээ шаардлага, арга барилыг тодорхойлох замаар тухайн орны чадавхи, өмчлөх эрхийг сайжруулах, (ii) худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасны дагуу дадлага олгох, бие даасан, туршлага солилцох сургалтыг явуулах замаар зөвлөх сонгон шалгаруулах талаар зээлдэгчийн чадавхийг дээшлүүлэх, (iii) дараах дөрвөн түвшинд чадавхийг бэхжүүлэх хэрэгцээ шаардлагад нийцүүлэн ХГО-ны зөвлөх үйлчилгээний салбарын хөгжлийг хангах,

- (а) бодлого/эрх зүйн түвшинд: салбарын хөгжлийг дэмжсэн бизнесийн таатай орчин бий болгох зорилгоор засгийн газрын үүргийг дэмжих,
- (б) зөвлөхийн ассоциац/нийгэмлэгийн түвшинд: салбарын сургалт явуулах, хүчтэй төлөөллийг хөгжүүлэх, чиглэлээр хангах,
- (в) зөвлөх компанийн түвшинд: дотоодын компанид “зөвлөх үйлчилгээний удирдлага”-ын арга туршлагыг шилжүүлэх шаардлагыг гадаадын зөвлөх компанийн АД-т тусгаж оруулах,
- (г) зөвлөх хувь хүний түвшинд: зөвлөх үйлчилгээний салбарын ажлын байрны боломжийн талаар мэдээлэл өгөх.

## Сургалт явуулах буюу мэдлэг шилжүүлэх

1.21 Хэрэв ажлын хүрээнд зээлдэгчийн ажилтан ба дотоодын зөвлөхийг сургах, тэдгээрт мэдлэг олгох сургалтыг чухал бүрэлдэхүүн гэж үзэн багтаасан бол АД-т сургалтын хөтөлбөрийн зорилго, шинж чанар, цар хүрээ, зорилт, түүний дотор сургагч багш болон сурагч, шилжүүлэх ур чадвар, цаг хугацаа, хяналт, үнэлгээ хийх гэх мэт дэлгэрэнгүй мэдээллийг тусгана. Сургалтын хөтөлбөрийн зардлыг ихэвчлэн зөвлөхийн гэрээ, ажлын төсөвт оруулна.

## Хэл

1.22 Зөвлөх үйлчилгээг ашиглах талаар АХБ, зээлдэгч, зөвлөхийн бэлтгэсэн аливаа баримт бичиг, захидал харилцааг англи хэл дээр явуулна.

## Залилан ба авлига

1.23 АХБ-ны авлигын эсрэг бодлого нь зээлдэгчийг (түүний дотор АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагааны үр шим хүртэгчид) төдийгүй АХБ-ны санхүүжилттэй гэрээний зөвлөхүүдийг сонгон шалгаруулах ажиллагаа болон гэрээний хэрэгжилтийн явцад ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлахыг шаарддаг. Энэ бодлогод<sup>13</sup> заасны дагуу, энэхүү зөвлөхийн журмын хүрээнд АХБ нь:

- (а) Энэхүү заалтын хүрээнд дор дурдсан нэр томъёог дараах байдлаар тодорхойлно:
  - (i) “авлигын үйлдэл” гэдэг нь бусад талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд ямар нэг үнэ цэнэтэй зүйлийг шууд эсвэл шууд бусаар санал болгох, өгөх, авах, эсхүл хүсэхийг;
  - (ii) “залилан мэхлэх үйлдэл” гэдэг нь санхүүгийн болон бусад үр шим хүртэх эсвэл үүрэг хариуцлагаас мултрах зорилгоор аливаа талыг санаатайгаар буюу санамсаргүйгээр төөрөгдүүлэх, эсвэл төөрөгдүүлэхийг оролдсон аливаа үйлдэл хийх, баримтыг орхигдуулах, худал мэдүүлэхийг;
  - (iii) “дарамт шахалт үзүүлэх үйлдэл” гэдэг нь аливаа талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа талд буюу түүний өмч хөрөнгөнд шууд эсвэл шууд бусаар хохирол учруулах, эсвэл хохирол учруулахаар заналхийлэхийг;
  - (iv) “үгсэн хуйвалдах үйлдэл” гэдэг нь хоёр буюу түүнээс дээш талууд зүй бус зорилгод хүрэх, түүний дотор бусад талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зорилгоор хоорондоо тохиролцоо хийхийг тус тус хэлнэ.
- (б) Гэрээний эрх олгохоор санал болгосон зөвлөх нь гэрээний эрхийн төлөө өрсөлдөх үед шууд өөрөө эсвэл төлөөлөгчөөр дамжуулан авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, эсвэл үгсэн хуйвалдах зэрэг үйлдэлд оролцсон болох нь тогтоогдвол гэрээний эрх олгох саналыг үл зөвшөөрнө;
- (в) АХБ-наас санхүүжилт авсан зээлдэгчийн төлөөлөгч нь зөвлөхийг сонгон шалгаруулах, эсвэл гэрээг хэрэгжүүлэх явцад авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, эсвэл үгсэн хуйвалдах зэрэг

<sup>13</sup> АХБ-ны Авлигын эсрэг бодлого, Шударга байдлын зарчим ба журмыг дараах вэб хуудаснаас үзнэ үү ([www.adb.org/Documents/Policies/Anticorruption](http://www.adb.org/Documents/Policies/Anticorruption)), ([www.adb.org/Documents/Guidelines/Integrity-Guidelines-Procedures](http://www.adb.org/Documents/Guidelines/Integrity-Guidelines-Procedures)).



Үйлдэлд оролцсон, мөн зээлдэгч энэ байдлыг засаж залруулах талаар АХБ-ны шаардлагад нийцэхүйц зохистой арга хэмжээг цаг тухайд нь аваагүй болох нь хэзээ нэгэн цагт тогтоогдвол тухайн гэрээнд хуваарилсан санхүүжилтийн хэсгийг хүчингүй болгоно;

- (г) Хэрэв компани ба хувь хүн шууд өөрөө эсвэл төлөөлөгчөөр дамжуулан авлига авах, залилан мэхлэх, дарамт шахалт үзүүлэх, эсвэл үгсэн хуйвалдах зэрэг үйлдэлд оролцсон болох нь тогтоогдвол, ийм зөвлөх компани, хувь хүн болон түүний залгамжлагчийг тодорхой эсхүл тодорхойгүй хугацаагаар АХБ-наас санхүүждэг, эсхүл АХБ-ны захиран зарцуулдаг арга хэмжээнд оролцох, эсвэл АХБ-наас санхүүждэг, эсхүл АХБ-ны захиран зарцуулдаг гэрээнээс санхүүгийн болон бусад хэлбэрээр үр шим хүртэх эрхгүй болохыг зарлах гэх мэтээр АХБ-ны авлигын эсрэг бодлого, шударга байдлын зарчим ба журам (тухай бүрдээ шинэчлэгдэж байдаг)-ын дагуу компани, хувь хүнд хориг тавина;
- (д) Зөвлөхүүдийн данс бүртгэл болон зөвлөхийн сонгон шалгаруулалт, гэрээний гүйцэтгэлтэй холбоотой баримт бичгийг хянан шалгах, АХБ-наас томилсон аудитын байгууллагаар тэдгээрийг хянуулахыг АХБ, түүний төлөөлөгчид зөвшөөрөхийг зөвлөхөөс хүссэн заалтыг зөвлөхийг сонгон шалгаруулах баримт бичиг болон гэрээнд тусгасан байхыг шаардах эрхтэй.

1.24 ТББ-т дурдсанаар зөвлөхүүд залилан ба авлига (хээл хахуулийг оруулан)-ын эсрэг тухайн орны хуулийг гэрээний эрхийн төлөө өрсөлдөх, гэрээг хэрэгжүүлэх үед дагаж мөрдөх тухай үүрэг хариуцлагыг АХБ-ны зээлдэгч шилжүүлсэн ТТ ба АХБ-ны санхүүжилттэй зээлийн төслийн хүрээнд АХБ-тай тусгайлан тохиролцсоны үндсэн дээр ТББ-т тусган оруулж болно. Ийм үүрэг хариуцлагыг зохицуулах арга зам нь АХБ-ны шаардлагад нийцэх талаар цохон тэмдэглэсэн АХБ-ны зээлдэгчийн хүсэлтийг үндэслэн АХБ дээрх үүрэг хариуцлагыг тусгаж оруулахыг зөвшөөрнө.

1.25 АХБ-наас гэрээг бүрэн буюу хэсэгчлэн санхүүжүүлэх тохиолдолд, тендерийн саналд зааснаас өөр аливаа хураамж, шан харамж, хөнгөлөлт урамшуулал, бэлэг сэлт, шимтгэл суутгал болон бусад төлбөрийг зөвлөхийг сонгон шалгаруулах, гэрээг хэрэгжүүлэхтэй хамааралтайгаар өгөөгүй, аваагүй, эсвэл амлаагүй болох тухай зөвлөхийн үүрэг хариуцлагыг гэрээний баримт бичигт оруулна.

## Гүйцэтгэлийн үнэлгээ

1.26 Урьд өмнө нь зөвлөхийн хийж гүйцэтгэсэн ажлын гүйцэтгэл нь түүний бизнесийн цаашдын боломжийг тодорхойлох ёстой гэж АХБ үздэг. АХБ, түүний зээлдэгч зөвлөхийн ажлын гүйцэтгэлд албан ёсны үнэлгээ хийнэ. Үнэлгээний ажлын нэг хэсгийн хувьд зөвлөх нь шилжүүлсэн ТТ, зээлийн төсөл, ТТ тус бүрт зээлдэгч ба АХБ-ны ажлын гүйцэтгэлд санал өгнө. Мөн зөвлөх нь зээлдэгч ба АХБ-наас бэлтгэсэн гүйцэтгэлийн үнэлгээний тайланг агуулгын хувьд хянаж, санал өгөх боломжтой болно.

## Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө

1.27 Зээл ба/ эсвэл буцалтгүй тусламжийн төслийг боловсруулахдаа, зээлдэгч нь АХБ-тай зөвлөлдсөний үндсэн дээр бараа, ажил, зөвлөх үйлчилгээний худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг (цаашид "төлөвлөгөө" гэх) аль болох эрт, ямар ч тохиолдолд зээлийн хэлэлцээнийхээс өмнө бэлтгэнэ. Зөвлөх үйлчилгээний тухайд, төлөвлөгөөнд (i) тухайн гэрээ бүрийн багц, (ii) зөвлөх үйлчилгээний сонгон шалгаруулалтын арга, тендерийн саналын төрөл, ба (iii) багц бүрийн сонгон шалгаруулах хугацаа, төсөвт өртөг зэргийг тусгана. Төлөвлөгөөг боловсруулснаар, тухайлбал, зөвлөх үйлчилгээний шаардлагыг тодорхойлох, АД-ыг боловсруулан батлах, дотоодын зөвлөхийг тодруулахад ихээхэн анхаарах гэх мэтээр зээлдэгчийн оролцоо, өмчлөл нэмэгдэнэ. Төлөвлөгөөг бэлтгэж эхлэхээс өмнө болон бэлтгэж байх үедээ шинэ зээлдэгчтэй, чадавхи сул зээлдэгчтэй, урьдчилсан ба дараа хяналт шаардлагатай, эсвэл ТТ-г зээлдэгчид шилжүүлсэн тохиолдолд АХБ нь төлөвлөгөөг хэрэгжүүлэх зээлдэгчийн чадавхийг үнэлж болно.<sup>14</sup> Энэ үнэлгээ нь гэрээ байгуулахаас өмнө болон дараа хийгдэх хяналтын шаардлага, давтамжийг тодорхойлох байдлаар төлөвлөгөөнд нөлөөлнө. Шаардлагатай гэж үзвэл, энэ үнэлгээгээр зээлдэгчийн сонгон шалгаруулалтын чадавхийг бэхжүүлэх сургалтыг тодорхойлж өгнө. Эхний төлөвлөгөөг хэдийгээр Ерөнхийлөгчийн тайлан, зөвлөмж (RRP)-д тусган оруулах боловч энэ нь шаардлагатай үед тодорхой хугацааны дараа шинэчлэгдэн өөрчлөгддөг төлөвлөгөө байх болно.

<sup>14</sup> Зааврыг гишүүн орны худалдан авах ажиллагааны үнэлгээний тайлан, зээлдэгчтэй АХБ ба бусад олон талт хөгжлийн банкны хамтран ажилласан туршлага, бусад материалаас харж болно.

## II. Сонгон шалгаруулах горим

### A. Сонгон шалгаруулалтын арга<sup>15</sup>

#### Зөвлөх компанийг авч ажиллуулах

2.1 АХБ (i) олон төрлийн үйлчилгээ үзүүлэх, (ii) оновчтой хялбар байлгах, бусад байгууллагатай уялдуулах, (iii) захиргааны шат дамжлага, зардлыг бууруулахын тулд сонгон шалгаруулалтын хэд хэдэн аргыг хэрэглэнэ.

#### a. Чанар ба үнэд суурилсан сонгон шалгаруулалт (ЧҮСС)

2.2 ЧҮСС нь зөвлөх үйлчилгээний техникийн саналын чанар, мөн үнэ өртөгт үндэслэнэ. ЧҮСС-ыг хэрэглэхэд тухайн санал болгосон зөвлөх үйлчилгээний үнэ өртөг нь сонгон шалгаруулалтын чухал хүчин зүйл болдог тул энэ аргыг (i) ажлын цар хэмжээг нарийн тодорхойлох боломжтой, (ii) АД нь дэлгэрэнгүй, ойлгомжтой, (iii) АХБ эсхүл зээлдэгч болон зөвлөхүүд мэргэжилтний ажиллах хугацаа, мөн бусад орцыг сайтар тооцоолох боломжтой үед хэрэглэнэ.

- (i) Зээл, шилжүүлсэн ТТ-ны төсөлд хэрэглэх Чанар ба үнэд суурилсан сонгон шалгаруулах горим

2.3 Хэрэв зээлдэгч зээл, шилжүүлсэн ТТ-ны зөвлөхийн сонгон шалгаруулалтыг хариуцан гүйцэтгэх бол энэ үед хэрэглэх ЧҮСС-ын горимыг дор дурдсанаар тайлбарлаж, 1 дүгээр хавсралтад хураангуйлан харуулав.

---

<sup>15</sup> Сонгон шалгаруулалтын арга тус бүрийн дэлгэрэнгүй мэдээллийг үйлдлээр нь АХБ-ны [www.adb.org](http://www.adb.org) вэб хуудсанд тавигдсан АХБ-ны ТУЗ-т тусган харуулна.

Зээлдэгч нь ихэвчлэн АХБ-аар батлуулах (урьдчилан хянуулах)-ын тулд (i) ТББ-ийн төсөл ба хураангуй жагсаалт, (ii) техникийн саналын үнэлгээний тайлан, (iii) нэгдсэн үнэлгээ ба эрэмбийн тайлан гэсэн 3 төрлийн материалыг явуулах шаардлагатай байдаг. Харин сонгон шалгаруулах чадвар сайн зээлдэгчийн хувьд (i) ТББ-ийн төсөл ба хураангуй жагсаалт, (ii) нэгдсэн үнэлгээ ба эрэмбийн тайлан гэсэн 2 материалыг АХБ-д явуулах хэрэгтэй.

а. Ажлын даалгаврыг боловсруулах

2.4 Санал болгож буй ажлын зорилго, цар хэмжээ, зөвлөхийн үүрэг хариуцлагыг зөвлөх компанийн сонгон шалгаруулалтыг эхлэхээс өмнө АД-т маш тодорхой, сайн тусгах ёстой.

б. Зардлын тооцоо (ажлын төсөв)

2.5 Зардлыг сайтар тооцож гаргах нь төсвийг бодитой тооцоолох боломжийг бүрдүүлж өгдөг. Зээлийн төслийн зардлын тооцоог бэлтгэхдээ зээлдэгч нь үйлчилгээг үзүүлэхэд шаардагдах зүйлүүд, тухайлбал, ажилтны ажиллах хугацаа, зохион байгуулалтын дэмжлэг, материаллаг туслалцаа (жишээ нь, унаа тээвэр, лабораторийн тоног төхөөрөмж) зэргийг ашиглана. Зардлыг (i) цалин хөлс (тухайн гэрээний төрлөөс хамааран) ба (ii) бусад зардал гэсэн хоёр үндсэн хэсэгт хуваана. Ажилтны ажиллах хугацааны зардлыг тооцоходоо гадаад ба дотоодын мэргэжилтний бодит жишгийг баримтална.

в. Зарлан мэдээлэх

2.6 Ихэвчлэн хураангуй жагсаалт гаргахаас өмнө АХБ нь зөвлөх үйлчилгээ шаардлагатай бүх зээлийн төслийн жагсаалтыг АХБ-ны вэб хуудсанд байршуулна. Зөвлөх компаниудын СИХ-ыг нэмэгдүүлэх үүднээс зээлдэгч нь үндэсний сонин, сэтгүүл, вэб хуудсанд зарлалыг гаргаж болно.

г. Зөвлөхүүдийн дэлгэрэнгүй жагсаалт гаргах

2.7 Зээлдэгч нь ирүүлсэн СИХ-ийг үндэслэн, техникийн шаардлага хангасан компаниудын дэлгэрэнгүй жагсаалтыг гаргана.

д. Зөвлөхүүдийн хураангуй жагсаалт гаргах

2.8 Зээлдэгч хураангуй жагсаалтыг гаргах үүрэгтэй. Ингэхдээ зээлдэгч нь тендерт оролцох сонирхолоо илэрхийлсэн компаниудаас холбогдох чадавхитай компаниудыг эхлээд авч үзнэ. Хураангуй жагсаалт нь газар зүйн хувьд илүү тархан байрласан зургаан компаниас бүрдэх ба нэг

орноос хоёроос дээшгүй компани, хөгжиж буй орноос чадварлаг компани олдохгүйг эс тооцвол доод тал нь хөгжиж буй орны нэг компани орсон байвал зохино. Онцгой тохиолдолд, тухайлбал, тухайн зөвлөх үйлчилгээний ажилд зөвхөн цөөн тооны, чадварлаг компани тендерт оролцох сонирхолоо илэрхийлсэн, эсхүл гэрээний цар хэмжээ нь хангалттай өрсөлдөөнийг бүрдүүлэхгүй байх тохиолдолд, АХБ цөөн компаниас бүрдэх хураангуй жагсаалтыг зөвшөөрч болно. Хураангуй жагсаалтыг гаргах зорилгоор компанийн улсын харьяалал нь тухайн улсад бүртгэлтэй эсхүл хуулийн этгээдээр бүртгэгдсэн улсаар тодорхойлогдох ба түншлэлийн тухайд түншлэлийг төлөөлөхөөр томилогдсон компанийн харьяалагдах улс байна. АХБ-наас хураангуй жагсаалтыг зөвшөөрсөнөөс хойш, зээлдэгч нь компанийн нэрийг нэмэх эсхүл хасч үл болно.

2.9 Хэрэв аливаа ажил нь АХБ-наас баталсан худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд заасан хязгаар (хязгаарууд)-аас<sup>16</sup> бага дүнтэй, эсхүл хангалттай тооны, чадвартай компаниуд өрсөлдөөнт зардалтай компаниас бүрдсэн хураангуй жагсаалтыг бүрдүүлэх боломжтой байгаа, эсхүл гадаад зөвлөхүүд өрсөлдөхгүй нь тодорхой, эсвэл гадаад зөвлөхүүд оролцох сонирхлоо илэрхийлээгүй тохиолдолд, хураангуй жагсаалт нь зөвхөн дотоодын зөвлөхүүд (тухайн улсад бүртгэлтэй, хуулийн этгээдээр бүртгэгдсэн компаниуд)-ээс бүрдэж болно. Салбарын аргачлалыг<sup>17</sup> дэмжих АХБ-ны зээлийн төслүүд (засгийн газрын ба хандивлагчдын санхүүжилттэй)-эд дээрхтэй ижил босгыг хэрэглэх бөгөөд үүнээс доогуур босготой нөхцөлд хураангуй жагсаалтыг АХБ-тай тохиролцсон горимын дагуу шалгаруулан дан ганц дотоодын компаниудиаас бүрдүүлж болно. Гэхдээ гадаад компани сонирхлоо илэрхийлсэн тохиолдолд, түүнийг мөн харгалзан үзэж болно.

е. Тендерийн баримт бичиг (ТББ)-ийг бэлтгэх, тараах

2.10 Зээлдэгч нь жишиг ТББ-ийг хэрэглэнэ. ТББ дараах зүйлсээс бүрдэнэ:

- Урилгын захидал;
- Зөвлөхөд өгөх зааварчилгаа (өгөгдлийн хүснэгт ба үнэлгээний шалгуур үзүүлэлт);

<sup>16</sup> Төслийн мөн чанар, дотоодын зөвлөхүүдийн чадвар, ажлын нарийн төвөгтэй байдал зэргээс хамаарч долларын хязгаарыг тогтоож болно. Энэ нь тухайн улс эсхүл зээлдэгчид зориулж гаргасан аливаа улсын худалдан авах ажиллагааны үнэлгээний тайлан (УХҮТ)-д тодорхойлсон хязгаараас хэтэрч үл болно.

<sup>17</sup> Салбарын аргачлал гэдэг нь тухайн улсын хөтөлбөрийг дэмжих зорилгоор хөгжлийн агентлагуудаас гаргасан аргачлалыг хэлэх бөгөөд уг хөтөлбөр нь хэмжээний хувьд нэг төслөөс илүү том байна. Энэ нь ихэвчлэн нэг салбарыг бүхэлд нь, эсхүл тухайн салбарын дийлэнх хэсгийг хамрана.

- Техникийн саналын жишиг маягт;
- Санхүүгийн саналын жишиг маягт;
- АД;
- Гэрээний жишиг маягт;
- Эрх бүхий орнуудын жагсаалт.

2.11 Зээлдэгч хураангуй жагсаалтад орсон зөвлөх рүү ТББ-ийг явуулна. АХБ цахим системийн хүрэлцээ хангалттай хэмээн үзвэл зээлдэгч ТББ-ийг тараахдаа цахим системийг ашиглаж болно. Хэрэв цахимаар дамжуулан ТББ-ийг тарааж байгаа нөхцөлд, цахим систем нь ТББ-ийг өөрчлөхөөс хамгаалагдсан байхаас гадна хураангуй жагсаалтанд багтсан зөвлөхүүд ТББ-т нэвтрэн хэрэглэхэд аливаа хязгаарлалтгүй байвал зохино.

#### ё. Саналыг хүлээж авах

2.12 Компани техникийн ба санхүүгийн саналыг тус тусад нь битүүмжлэн дугтуйнд хийж нэг зэрэг ирүүлнэ. Санал хүлээн авах эцсийн хугацаанаас хойш ирүүлсэн саналыг задалж нээхгүйгээр буцаах ба дээрх хугацаа дууссанаас хойш техникийн ба санхүүгийн саналыг өөрчлөхийг хүлээн зөвшөөрөхгүй.

#### ж. Техникийн саналыг үнэлэх

2.13 Үнэлгээг зөвлөхөд өгөх зааварчилгаанд тодорхойлсон үнэлгээний шалгуур үзүүлэлтэнд үндэслэн хийнэ. Техникийн чадавхийн үнэлгээний дараа техникийн санал нь нийт авах ёстой 1,000 онооноос авбал зохих доод оноо болох 750 оноог авч чадаагүй, мөн шаардлагад нийцээгүй компаниудад энэ тухай мэдэгдэж, тэдгээрийн санхүүгийн саналыг нээлгүйгээр буцаана. Техникийн саналд авбал зохих доод оноо авсан компаниудад санхүүгийн саналыг нээх газар, өдөр, цагийг мэдэгдэнэ.

#### з. Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээх

2.14 Зээлдэгч 750 ба түүнээс дээш оноог хангасан техникийн саналтай компаниудад санхүүгийн саналыг нийтийн өмнө нээх өдөр, цаг, газрыг мэдэгдэнэ. Санхүүгийн саналыг нээхдээ компанийн нэр, техникийн оноо, санал болгосон үнийг зарлаж, тэмдэглэл хөтөлнө.

## и. Санхүүгийн саналыг үнэлэх

2.15 Зээлдэгч нь техникийн ба санхүүгийн санал хоорондоо тохирч байгаа эсэхийг хянаж, шаардлагатай бол залруулга хийх бөгөөд арифметик болон тооцооллын алдааг засна.

## й. Саналуудыг эрэмбэлэн жагсаах

2.16 Техникийн болон санхүүгийн онооны хувийн жинг тооцож, хооронд нь нэмэх байдлаар нийт оноог гаргаж, зөвлөхүүдийн саналыг эрэмбэлэн жагсаана. Үнийн хувийн жинг сонгохдоо ажлын нарийн төвөгтэй байдал, чанарын шаардлагын ач холбогдол зэргийг харгалзана. Бусад сонгон шалгаруулалтын аргыг эс тооцвол, үнийн хувийн жин ихэвчлэн 20 хувь байна.

## к. Хэлэлцээ хийх

2.17 Зээлдэгч хамгийн өндөр оноо авсан компанитай хэлэлцээ хийнэ. Хэлэлцээ хийх үед АД, аргачлал, мэргэжилтний хуваарь, зээлдэгчийн зүгээс гаргах оффис, тоног төхөөрөмж, бусад зүйл, компанийн санхүүгийн санал дахь зардлын зүйл ангийн тоо хэмжээг ярилцана. Гэхдээ эдгээр зүйлсийг ярилцах үеэр урилгад хавсаргасан АД-ыг их хэмжээгээр өөрчилж болохгүй. Сонгон шалгаруулалтын удааширал ажилтныг солиход хүргэсэн, эсхүл ажлын зорилгыг биелүүлэх үүднээс зайлшгүй солих шаардлагатай гэж хоёр тал тохиролцоноос бусад тохиолдолд сонгон шалгарсан компани ажилтнаа сольж болохгүй.<sup>18</sup> Нэгж үнэ нь сонгон шалгаруулалтын нэг хүчин зүйл болдог тул санал болгосон цалингийн нэгж үнийг өөрчилж болохгүй, бусад зардлыг ч мөн хэлэлцэн тохиролцож болохгүй. Хэлэлцээ амжилттай дуусвал гэрээнд гарын үсэг зурна. Санхүүгийн хэлэлцээний үед зээлдэгч оронд зөвлөхийн төлөх татвар (хэрэв байгаа бол), түүнийг гэрээнд хэрхэн тусгасан болон тусгах талаар хэлэлцэж болно. Хэрэв зээлдэгч ба компани хоёр тохиролцоонд эс хүрвэл, зээлдэгч АХБ-тай урьдчилан тохиролцсоны дагуу хэлэлцээг зогсоож, удаах өндөр оноо авсан компанитай хэлэлцээг эхэлж, харилцан тохиролцох хүртлээ үргэлжлүүлнэ. Зээлдэгч гарын үсэг зурсан гэрээний хуулбарыг АХБ руу илгээнэ.

<sup>18</sup> ТББ-т саналын хүчинтэй хугацааг бодитойгоор тодорхойлж үр ашигтай үнэлгээг хийснээр эрсдлийг бууруулж болно.

л. Гэрээний эрх олгосон тухай нийтэд мэдээлэх

2.18 Гэрээнд эрх олгосны дараа зээлдэгч АХБ-нд дараах мэдээллийг өгсөнөөр АХБ өөрийн вэб хуудсанд<sup>19</sup> байрлуулна. Үүнд: (i) тендерийн санал ирүүлсэн бүх зөвлөхүүдийн нэр, (ii) зөвлөх бүрийн техникийн оноо, (iii) зөвлөх бүрийн санхүүгийн санал, (iv) зөвлөхүүдийн онооны эрэмбэлэл, (v) шалгарсан зөвлөхийн нэр ба гэрээний үнийн дүн орно.

м. Тайлбар хүсэх

2.19 Санал ирүүлсэн зөвлөх яагаад түүний санал шалгараагүй болсон шалтгааныг мэдэхийг хүсвэл зээлдэгчээс тайлбар авах эрхтэй болохыг зээлдэгч нь гэрээний эрх олгосон тухай мэдээлэлд дурдана. Зээлдэгч яагаад зөвлөхийн санал сонгогдоогүй тайлбарыг нэн даруй өгнө.

н. Бүх саналаас татгалзах, дахин шинээр урилга явуулах

2.20 Зөвхөн бүх тендерийн санал АД-аас том зөрүүтэйн улмаас бүх санал шаардлага хангаагүй, эсхүл эдгээр саналын үнэ нь анхны төсөвт өртгөөс их хэмжээгээр хэтэрсэн тохиолдолд зээлдэгч бүх саналаас татгалзах эрхтэй болно. Хоёр дахь буюу үнэ хэтэрсэн тохиолдолд, төсөвт өртгийг нэмэгдүүлэх, эсхүл компанийн үйлчилгээний хэмжээг бууруулах боломжийг АХБ-тай зөвшилцсөний дараа судалж үзнэ. Зээлдэгч нь бүх саналаас татгалзаж, шинээр урилга явуулахын өмнө бүх саналаас татгалзсан шалтгааныг АХБ-нд мэдэгдэж, татгалзах буюу шинээр урилга явуулахын өмнө АХБ-наас зөвшөөрөл авна. Шинээр урилга тараахдаа ТББ (хураангуй жагсаалтыг оролцуулан) ба төсөвт өртөгийг өөрчилж болно. Өөрчлөлтийг хийхдээ АХБ-наас зөвшөөрөл авсан байвал зохино.

о. Нууцлал

2.21 2.14 ба 2.16 дугаар зүйлд зааснаас бусад тохиолдолд, саналын үнэлгээ, гэрээний эрх олгох зөвлөмжтэй холбоотой мэдээллийг санал ирүүлсэн зөвлөх, эсвэл гэрээний эрхийг нийтэд зарлах хүртэл ажиллагаатай албан ёсоор холбоогүй хүмүүст мэдээлж үл болно.

<sup>19</sup> www.adb.org



- (ii) Техник туслалцааны төсөлд хэрэглэх Чанар ба үнэд суурилсан сонгон шалгаруулах горим

2.22 ТТ-ны төсөлд баримтлах горим нь зээл, шилжүүлсэн ТТ-ны төслийн зөвлөхийг сонгон шалгаруулах горимтой адилхан байх бөгөөд 1 дүгээр хавсралтад хураангуйлан үзүүлэв.

## **6. Чанарт суурилсан сонгон шалгаруулалт (ЧСС)**

2.23 Чанарт суурилсан сонгон шалгаруулалт (ЧСС) гэдэг нь зөвхөн техникийн саналын чанарыг үнэлж, хамгийн өндөр оноо техникийн санал ирүүлсэн зөвлөхтэй санхүүгийн санал ба гэрээний хэлэлцээ хийх аргыг хэлнэ. ЧСС-ыг дараах тохиолдолд, тухайлбал, (i) нарийн төвөгтэй эсвэл маш өндөр мэргэжлийн ажлын улмаас АД, зөвлөхийн орцыг нарийвчлан тогтооход хүндрэлтэй, (ii) үйлчилгээний чанар нь төслийн үр дүнд хамгийн чухал нөлөө үзүүлэхүйц ач холбогдолтой ажил бол, (iii) ажлыг өөр арга хэлбэрээр гүйцэтгэж болох учраас санхүүгийн саналыг харьцуулах боломжгүй зэрэг тохиолдолд хэрэглэхэд тохиромжтой.

- (i) Чанарт суурилсан сонгон шалгаруулалтыг зээл ба шилжүүлсэн ТТ-ны төсөлд хэрэглэх

2.24 Ерөнхийдөө, ЧСС-ыг хэрэглэх үед үнийг сонгон шалгаруулалтын үзүүлэлт болгон ашигладаггүй тул ТББ-т зааснаар компаниуд зөвхөн техникийн саналыг бэлтгэн ирүүлнэ. Зээлдэгч нь зөвлөхүүдийн техникийн саналыг үнэлэн эрэмбэлэхдээ ЧУСС-ын аргатай ижил аргачлалыг ашиглах ба хамгийн өндөр оноо авсан техникийн саналтай зөвлөхийг санхүүгийн саналаа бусад санхүүгийн баримтын хамт дэлгэрэнгүй ирүүлэхийг хүснэ. Санхүүгийн эдгээр материалд аудит хийж болно. Үүний дараа зээлдэгч, зөвлөх нар санхүүгийн санал, гэрээний талаар хэлэлцээ хийнэ. Сонгон шалгаруулалтын бусад бүх үйл явц (гэрээний эрхийг нийтэд мэдээлэхийг оруулан) нь ЧУСС-ын аргатай адилхан байна. Харин гэрээний эрх олгосон тухай мэдээлэлд зөвхөн шалгарсан компанийн үнийг нийтлэнэ. Сонгон шалгаруулах явцад бүх зээлдэгч нь (урьдчилан хянах механизмын дагуу) хоёр материалыг, тухайлбал, (i) хураангуй жагсаалт болон (ii) эцсийн үнэлгээг АХБ-нд явуулж зөвшөөрөл авна. Горимыг 1 дүгээр хавсралтад хураангуйлан үзүүлэв.

(ii) Чанарт суурилсан сонгон шалгаруулалтыг ТТ-ны төсөлд хэрэглэх

2.25 ТТ-ны төсөлд баримтлах горим нь зээл, шилжүүлсэн ТТ-ны төслийн зөвлөх сонгон шалгаруулах горимтой адилхан байх бөгөөд 1 дүгээр хавсралтад хураангуйлан үзүүлэв.

#### **в. Тогтмол төсвийн сонгон шалгаруулалт (ТТС)**

2.26 Тогтмол төсвийн сонгон шалгаруулалт (ТТС)-ыг зөвхөн (i) АД-ыг нарийвчлан тодорхойлсон, (ii) хугацаа, мэргэжилтний орцыг нарийн судалж болох, (iii) тогтсон төсөвт өртөгтэй, түүнээс хэтэрч болохгүй зэрэг тохиолдолд ашиглахад тохиромжтой. Зөвлөхөд тулгарах санхүүгийн эрсдэлийг бууруулах, шаардлагад үл нийцэх техникийн санал хүлээж авах, эсхүл ямар ч санал хүлээж авахгүй байхаас зайлсхийхийн тулд энэ аргыг зөвхөн сайтар боловсруулсан ТТ-ны төсөл, эсвэл хэрэгжилтийн явцад ямар нэгэн өөрчлөлт гарахгүй төсөлд л хэрэглэнэ. ТТС-ын хураангуй жагсаалт нь ихэвчлэн газар зүйн хувьд тархмал зургаан компаниас бүрдэнэ. ТББ-т төсөвт өртгийг дурдан, чанараар авбал зохих доод оноо нь нийт авах ёстой 1,000 онооноос 750 оноо байхаар тусгаж, маш сайн техникийн ба санхүүгийн саналыг тус тусад нь дугтуйлан, заасан төсөвт багтаан ирүүлэхийг компаниудаас хүснэ. Эхлээд бүх техникийн саналын үнэлгээг хийнэ. Дараа нь техникийн шаардлага хангасан компаниудын санхүүгийн саналыг нийтийн өмнө нээж, үнийг зарлана. Заасан төсвөөс хэтэрсэн саналаас татгалзана. Үлдсэн саналуудаас хамгийн сайн техникийн санал ирүүлсэн зөвлөхийг сонгож, хэлэлцээнд урина. Хэлэлцээ амжилтгүй болвол зээлдэгч эсхүл АХБ удаах өндөр оноо авсан компанитай хэлэлцээг эхэлж, харилцан тохиролцох хүртлээ үргэлжлүүлнэ.

#### **г. Бага үнийн сонгон шалгаруулалт (БҮС)**

2.27 Бага үнийн сонгон шалгаруулалтыг зөвхөн тогтсон арга зүй, стандарттай бөгөөд хэвшсэн, жишиг шинж бүхий (аудит, энгийн төслийн инженерийн зураг төсөл/хяналт, ба энгийн судалгаа) маш жижиг ажилд<sup>20</sup> хэрэглэхэд тохиромжтой. БҮС-ын хураангуй жагсаалт нь ихэвчлэн газар зүйн хувьд тархмал гурван компаниас бүрдэнэ. ТББ-т чанараар авбал зохих доод оноо нь нийт авах ёстой 1,000 онооноос 750

<sup>20</sup> Ерөнхийдөө 100,000 америк доллараас бага.

оноо байхаар тусгаж, маш сайн техникийн ба санхүүгийн саналыг тус тусад нь дугтуйлан ирүүлэхийг компаниудаас хүснэ. Эхлээд техникийн саналыг нээн үнэлнэ. Техникийн доод шаардлагыг хангаагүй саналуудыг хасч, үлдсэн компаниудын санхүүгийн саналыг нийтийн өмнө нээнэ. Хамгийн бага үнийн саналтай компанийг сонгон шалгаруулж, гэрээг эцэслэн байгуулахаар урина. Хэлэлцээ амжилтгүй болвол зээлдэгч эсхүл АХБ удаах өндөр оноо авсан компанитай хэлэлцээг эхэлж, харилцан тохиролцох хүртлээ үргэлжлүүлнэ.

#### **д. Зөвлөхийн чадварын сонгон шалгаруулалт (ЗЧС)**

2.28 Энэ аргыг (i) ажил нь мэргэжлийн маш өндөр чадвар мэдлэг шаардсан байх, “чадвартай, жижиг” зөвлөх компанийг авч ажиллуулах тул тодорхой салбараар гүнзгий мэргэшиж туршлагажсан байдлыг харгалзан үзэх, (ii) түргэн хугацаанд авч ажиллуулах, богино хугацааны ажил шаардлагатай болсон, (iii) мэргэшсэн зөвлөхүүдийн тоо цөөн байдаг, (iv) саналыг өрсөлдүүлэн боловсруулах, үнэлэх үндэслэлгүй гэх мэт жижиг ажилд<sup>21</sup> хэрэглэхэд тохиромжтой. Зээлдэгч эсхүл АХБ (i) АД-ыг бэлтгэж, (ii) дэлгэрэнгүй СИХ, зөвлөхийн туршлага, ур чадварын мэдээлэл хүсч, (iii) гурваас доошгүй компаниас бүрдсэн хураангуй жагсаалтыг гарган, (iv) СИХ-ийг үндэслэн, хамгийн сайн ур чадвар, тодорхойлолттой компанийг сонгон шалгаруулна. Шалгарсан компанийг техникийн ба санхүүгийн нэгтгэсэн саналаа ирүүлэхийг хүссэний дараа гэрээний хэлэлцээнд урина. Хэлэлцээ амжилтгүй болвол зээлдэгч эсхүл АХБ удаах өндөр оноо авсан компанитай хэлэлцээг эхэлж, харилцан тохиролцох хүртлээ үргэлжлүүлнэ.

#### **е. Нэг эх үүсвэрээс сонгон шалгаруулах (НЭС)**

2.29 Зөвлөхийг нэг эх үүсвэрээс сонгон шалгаруулах (НЭС) нь чанар, үнийн өрсөлдөөний давуу шинжийг хангахгүй, сонгон шалгаруулалтын ил тод байдлыг алдагдуулж, зохисгүй үйлдлийг дэвэргэж болзошгүй байдаг. Иймд НЭС аргыг зөвхөн онцгой тохиолдолд л хэрэглэнэ. НЭС-ын үндэслэлийг хянаж үзэхдээ, захиалагчийн болон төслийн нийт ашиг сонирхол, АХБ-ны хариуцлага, жишээ нь хэмнэлттэй, үр ашигтай байх, бүх чадварлаг зөвлөхөд ижил тэгш боломжийг олгох зэргийг харгалзана.

---

<sup>21</sup> Ерөнхийдөө 200,000 америк доллараас бага.

2.30 НЭС нь (i) компанийн өмнө нь гүйцэтгэсэн ажлын үргэлжлэл ажил мөн бол (дараагийн зүйлийг үзэх), (ii) байгалийн гамшиг сүйрлийг арилгах гэх мэт онц яаралтай тохиолдолд, (iii) маш жижиг<sup>22</sup> ажил бол, эсвэл (iv) ажлыг гүйцэтгэх чадвартай, эсвэл энэ чиглэлээр онцгой туршлагатай цорын ганц компани байх гэх зэрэг өрсөлдөөнөөс илэрхий давуу талтай тохиолдолд л тохиромжтой байдаг.

2.31 Ажлыг дараа нь үргэлжлүүлэн гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай бол ТББ-т энэ тухай анхнаас нь зааж өгөх ба хэрэв боломжтой бол ийнхүү цаашид үргэлжлүүлэх магадлалыг зөвлөхийг шалгаруулахад ашиглах хүчин зүйлд харгалзан үзнэ. Техникийн арга замын залгамж чанарыг хадгалах, энэ чиглэлээр туршлага хуримтлуулсан, үргэлжлүүлэн мэргэжлийн хариуцлага хүлээх чадвартай бөгөөд эхний ажлыг хангалттай сайн гүйцэтгэсэн бол анхны зөвлөхийг үргэлжлүүлэн ажиллуулах нь шинэ өрсөлдөөнт шалгаруулалтаас илүү дээр байх болно. Ийм үргэлжлэл ажлын хувьд зээлдэгч анх шалгарсан зөвлөхөөс зээлдэгчийн боловсруулсан АД-т нийцүүлэн техникийн ба санхүүгийн санал бэлтгэхийг хүсч, дараа нь хэлэлцээ хийнэ. Хэрэв анхны ажлыг өрсөлдөөнт аргаар шалгаруулаагүй, үргэлжлэх ажил нь өмнөхөөсөө өртөг өндөртэй байвал АХБ-ны шаардлага хангасан өрсөлдөөнт шалгаруулалт явуулах бөгөөд анхны ажлыг хэрэгжүүлсэн зөвлөх оролцох сонирхлоо ирүүлбэл түүнийг мөн оруулж болно. Зөвхөн онцгой тохиолдолд эсхүл өрсөлдөөнт шалгаруулалт явуулах боломжгүй бол АХБ энэ дүрмийг баримтлахгүй байж болно.

2.32 Зээлдэгч эсхүл АХБ НЭС-ыг хэрэглэхийг санал болгож байвал АХБ-ын ажлын хэсэг энэ аргыг ТТ-ны төслийн баримт бичиг, Ерөнхийлөгчийн тайлан зөвлөмжид тусгана. Зээлдэгч эсхүл АХБ намтарын техникийн санал (НТС)<sup>23</sup> ба санхүүгийн саналыг нэг зэрэг зөвлөхөөс ирүүлэхийг хүснэ. АХБ эсхүл зээлдэгч НТС-ыг хангалттай байгаа эсэхийг хянаж, компани эсхүл хувь хүнтэй гэрээний хэлэлцээ хийнэ.

<sup>22</sup> “Маш жижиг” гэсэн долларын босгыг тухайн тохиолдолд ажлын мөн чанар, нарийн төвөгтэй байдлыг харгалзан тогтоох бөгөөд 100,000 америк доллараас хэтрэхгүй үнийн дүнтэй байна.

<sup>23</sup> НТС нь ажлын төлөвлөгөө, мэргэжилтний хуваарь, санал болгож буй бүх зөвлөхийн анкет намтараас бүрдэнэ.

## ё. Арилжааны практик арга

2.33 Хувийн хэвшлийн компани эсхүл арилжааны хувьд бие даасан төрийн өмчийн үйлдвэр аж ахуйн газруудад санхүүгийн зуучлагчаар дамжуулан зээлдүүлсэн зээлийн тохиолдолд, дамжуулан зээлдэгч нь хувийн хэвшил эсвэл арилжааны практикт сайн төлөвшиж тогтсон аргыг АХБ-ны зөвшөөрөлтэйгөөр хэрэглэн мөрдөж болно. Түүнчлэн өмнө өгүүлсэн өрсөлдөөнт аргыг ялангуяа том ажилд ашиглаж болно.

### Зөвлөх хувь хүнийг авч ажиллуулах

2.34 Зарим ажлын хувьд зөвлөх хувь хүн нь компаниас илүү тохиромжтой, мөн зардлын хувьд хэмнэлттэй байдаг. Зээлдэгч эсхүл АХБ нь хувь хүнийг шууд (бие даасан хувь хүн) эсхүл компаниар, тухайлбал зөвлөх компани, их дээд сургууль, засгийн газар, олон улсын байгууллагаар дамжуулан авч ажиллуулж болно. Сонгон шалгаруулах горим нь гадаад, дотоодын зөвлөх компанийг сонгон шалгаруулахаас илүү хялбар байдаг. Зөвлөх хувь хүнийг ажлын ур чадварт үндэслэн шалгаруулна. Зээлдэгч зээлийн төслийн гадаад, дотоодын зөвлөхийг авч ажиллуулах үед, аль болох эрт, тухайлбал (i) ажилд хамгийн илүү тохирох зөвлөхийн төрөл, (ii) хэрэглэж мөрдөх горим зэрэг асуудлаар зээлийн хэлэлцээ хийхээс өмнө тохиролцоонд хүрэх ёстой. Ихэнхдээ зээлдэгч зөвлөх хувь хүнийг засгийн газрын журмаар шалгаруулж ажиллуулдаг ба энэ нь АХБ-ны хувьд хүлээн зөвшөөрөхүйц байх ёстой. ТТ-ны төсөлд сонгон шалгаруулах горим нь АД-ын нарийн төвөгтэй байдал,<sup>24</sup> ажлын хугацаанаас хамаарна.

### Тусгай зөвлөхийг авч ажиллуулах

#### а. Зөвлөх ажилтан

2.35 АХБ нь зөвлөх ажилтанд тавигдах шаардлагыг тодорхойлж, АД-ыг бэлтгэнэ. АХБ ирүүлсэн СИХ, ба тохирох нэр дэвшигчид зориулсан, зөвлөх хувь хүний мэдээлэл (ЗХМ)-ийг хянаж, шаардлагатай бол байгууллага, зөвлөх компаниас тохирох хүнээ нэр дэвшүүлэхийг хүснэ.

<sup>24</sup> Энэ тохиолдолд нарийн төвөгтэй байдал гэдэг нь "ажлын түвшин" (ажлын үүрэг хариуцлага, зөвлөхөд тавигдах ур чадвар, туршлагад үндэслэн)-гээр тодорхойлогдоно.

## **б. Нөөц ажилтан**

2.36 Нөөц ажилтныг 10-аас дээш ажлын өдрөөр авч ажиллуулахгүй ба нэг эх үүсвэрийн аргыг ашиглан сонгон шалгаруулж болно.

## **в. НҮБ ба бусад мэргэшсэн байгууллагууд**

2.37 Өөрсдийн мэргэшсэн чиглэлээр техник туслалцаа, зөвлөгөө өгөх чадвартай бол НҮБ ба бусад ижил төстэй мэргэшсэн байгууллагуудыг зөвлөхөөр авч ажиллуулж болно. Зээлдэгч олон улсын гэрээ конвенцийн хүрээнд НҮБ-ын агентлагууд, түүний ажилтнуудын тусгай эрх ямба, халдашгүй дархан байдлыг хүлээн зөвшөөрч, АХБ-наас зөвшөөрсний дагуу агентлагийн дүрэм ёсоор төлбөрийн тусгай нөхцөл мөрдөх талаар НҮБ-ын агентлагтай зөвшилцөхөөс бусад тохиолдолд өрсөлдөөнт шалгаруулалтын явцад ямар нэгэн давуу эрхийг тус байгууллага, ажилтнууд эдлэхгүй. НҮБ-ын агентлагуудын тусгай эрх ямба, мөн бусад давуу талууд, тухайлбал татварын хөнгөлөлт, эрх хангамж, төлбөрийн тусгай нөхцөл зэргийг саармагжуулах үүднээс ЧСС-ын аргыг ашиглана. Энэхүү журмын 2.29 дүгээр зүйлд заасан шалгуур үзүүлэлт хангагдвал НЭС аргыг үндэслэн НҮБ-ын агентлагыг авч ажиллуулж болно.

## **г. Төрийн бус байгууллага (ТөББ)**

2.38 Үйл ажиллагааны үр ашиг, чанар, тогтвортой байдлыг сайжруулахын тулд АХБ чиглэл бүрээр олон улсын болон дотоодын ТөББ-уудтай хамтран ажилладаг. Хэрэв АХБ эсвэл зээлдэгч олон улсын том ТөББ-ыг хангалттай чадвартай гэж үзвэл, зарим үед тэдгээр ТөББ-ыг ТТ-ны болон зээлийн төслийн зөвлөхийн хураангуй жагсаалтад оруулна. Жижиг хэмжээний (ялангуяа дотоодын) ТөББ-уудыг авч ажиллуулахдаа сонгон шалгаруулалтын ба гэрээний хялбар горимыг мөрдөнө. Олон улсын ТөББ нь ТТ-ны болон зээлийн төслийн зөвлөхийн хураангуй жагсаалтад зөвлөх компаниудтай хамт орсон тохиолдолд ЧСС-ын аргыг хэрэглэнэ. ТТ-ны төсөл эсхүл зээлийн төсөл нь орон нутгийн асуудал, нутгийн иргэдийн хэрэгцээний талаар гүнзгий мэдлэг болон/эсхүл олон улсын эсхүл дотоодын илт чадварлаг ТөББ-ын оролцоотой арга хэлбэр шаардлагатай үед хураангуй жагсаалтыг дан ганц ТөББ-уудаар бүрдүүлж болох ба сонгон шалгаруулалтад ЧҮСС-ын аргыг ашиглана. ТТ-ны болон зээлийн төсөлд дотоодын ТөББ-ыг авч ажиллуулах үед АХБ өрсөлдөж буй ТөББ-ын чадавхийг харгалзан ЧҮСС-ын аргыг өөрчлөн (хялбарчлан)

хэрэглэх ба ТөББ-ын онцгой чадварыг үнэлэх шалгуур үзүүлэлтэд (i) орон нутгийн хүмүүстэй хамтран ажиллаж байсан туршлага, ажлыг хангалттай гүйцэтгэсэн нотолгоо, (ii) оролцооны хөгжлийн аргын талаарх мэдлэг, (iii) манлайлал, удирдлага сайтай байх, (iv) үр шим хүртэгчдийг татан оролцуулах чадавхи зэргийг тусгана. Энэхүү журмын 2.29 дүгээр зүйлд заасан шалгуур үзүүлэлт хангагдвал АХБ ба зээлдэгч ТөББ-ыг НЭС-ын аргын дагуу сонгон шалгаруулж болно.

#### **д. Худалдан авах ажиллагааны төлөөлөгч (ХТ)**

2.39 Зээлдэгч нь шаардлагатай зохион байгуулалт, нөөц болон туршлагаар хомс үед худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн компанийг өөрийн төлөөлөгчөөр ажиллуулах нь илүү үр ашигтай, үр дүнтэй байх болно. Тодорхой худалдан авах ажиллагааг хариуцуулан гүйцэтгэж, ихэвчлэн өөрийнх нь байрнаас ажлаа явуулах байдлаар ХТ-ийг “төлөөлөгч”-өөр ашиглах тохиолдолд тэдэнд хийж гүйцэтгэсэн худалдан авах ажиллагааны үнийн дүнгийн тодорхой хувиар, эсвэл энэ тодорхой хувь ба тогтмол хөлсийг хослуулсан аргаар төлбөрийг хийнэ. Энэ тохиолдолд ХТ-ийг сонгон шалгаруулахдаа нийт онооны 50 хүртэл хувийн жинг үнэ эзлэх нөхцөлтэйгөөр ЧҮСС-ын аргыг хэрэглэнэ. Гэхдээ ХТ нь худалдан авах ажиллагаанд зөвхөн зөвлөх үүрэг гүйцэтгэх эсвэл төслийг нийтэд нь хариуцсан “төлөөлөгч”-өөр тухайн төслийн тусгайлсан байранд ажиллах бол тэдний хөлсийг ихэвчлэн цагаар тооцож төлнө. Энэ тохиолдолд тэднийг энэхүү журамд заасан ЧҮСС-ын арга, хугацаанд суурилсан гэрээг ашиглан, бусад зөвлөх ажлын жишгийг баримтлан сонгон шалгаруулна. Төлөөлөгч нь зээлдэгчийн нэрийн өмнөөс АХБ-аас баталсан зээлийн гэрээ ба худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд дурдсан худалдан авах ажиллагааны бүхий л горим, жишээлбэл, ТББ ашиглах, хянах горим болон бичиг баримт бүрдүүлэх журмыг дагаж мөрдөнө.

#### **е. Хянан шалгах төлөөлөгч**

2.40 Барааг ачуулахаас өмнө эсвэл зээлдэгч оронд ирэх үед шалгаж баталгаажуулахын тулд зээлдэгч хянан шалгах төлөөлөгчийг авч ажиллуулж болно. Ийм төлөөлөгчийн хяналт шалгалт нь ихэвчлэн тухайн барааны чанар, тоо хэмжээ ба үнийн бодитой байдлыг хамрана. Хянан шалгах төлөөлөгчийг сонгон шалгаруулахдаа нийт онооны 50 хүртэл хувийн жинг үнэ эзлэх нөхцөлтэйгөөр ЧҮСС-ын аргыг хэрэглэх ба шалгаж баталгаажуулсан барааны өртгийн хувь хэмжээнд үндэслэн төлбөр хийх гэрээг ашиглана.

## ё. Банк

2.41 Хувьчлах үйл ажиллагаатай уялдан хөрөнгө худалдах, хувьцаа, бонд зэрэг санхүүгийн хэрэгсэл гаргах, байгууллагын санхүүгийн бусад хэлцэл хийх зорилгоор зээлдэгч нь хөрөнгө оруулалт ба арилжааны банк, санхүүгийн компани, сангийн менежерийг авч ажиллуулахдаа ЧҮСС-ын аргаар сонгон шалгаруулна. ТББ-т ижил төстэй ажлын туршлага, эсвэл боломжит худалдан авагчдын сүлжээ гэх мэт үйл ажиллагааны үзүүлэлт, мөн үйлчилгээний үнэд хамаарах үнэлгээний шалгуур үзүүлэлтийг тусгана. Үндсэн цалин хөлс (“урьдчилгаа хөлс” гэж нэрлэдэг)-нөөс гадна, “үр дүнгийн хөлс”-ийг тогтмол хэмжээгээр нэмж төлөхдөө ихэвчлэн худалдсан хөрөнгө, бусад санхүүгийн хэрэгслүүдийн үнийн дүнгийн хувиар илэрхийлнэ. Үнийн үнэлгээнд үр дүнгийн хөлсийг урьдчилгаа хөлстэй хослуулан эсвэл дангаар нь авч үзэх талаар ТББ-т тусгана. Хэрэв дангаар нь харгалзан үзэх бол хураангуй жагсаалтын бүх зөвлөхүүдэд нэг жишиг урьдчилгаа хөлсийг тогтоон ТББ-т тусгах ба санхүүгийн оноог үр дүнгийн хөлсөнд үндэслэн гаргана. Урьдчилгаа хөлстэй хослуулах (ихэвчлэн том гэрээнд) бол үнийн хувийн жин нь 2.16 дугаар зүйлд зааснаас илүү өндөр тогтоох, эсхүл саналын чанарын босгыг давсан зөвлөхүүдийн дан ганц үнийн саналаар сонгон шалгаруулна. ТББ-т саналыг хэрхэн бэлтгэж ирүүлэх, хэрхэн харьцуулж үнэлэх талаар тодорхой зааж өгнө.

## ж. Аудитын компани

2.42 Аудитын компани аудитыг ихэвчлэн маш сайн боловсруулсан АД, мэргэжлийн стандартын дагуу хийдэг. Түүнийг нийт онооны 50 хүртэл хувийг үнийн саналд өгөх нөхцөл бүхий ЧҮСС-ын аргаар, эсвэл 2.27 дугаар зүйлд заасан БҮС-ын аргаар сонгон шалгаруулна. Маш жижиг хэмжээний<sup>25</sup> ажилд ЗЧС-ын аргыг хэрэглэнэ.

## з. Үйлчилгээ үзүүлэх ажил

2.43 Сургах, төслийн сургалтын материал, сурталчилгааны материал эсвэл видео материалыг боловсруулан хэвлүүлэх, сургалт семинарыг төлөвлөн зохион байгуулах зэрэг туслах үйлчилгээ шаардсан төсөлд ийм үйлчилгээ үзүүлдэг хувь хүн эсхүл мэргэшсэн байгууллагыг гэрээний үндсэн дээр ажиллуулж болно. АД-ыг бэлтгэнэ. Нийт үнийн гэрээг (2.48 дугаар зүйлийг үзэх) үйлчилгээ үзүүлэгчтэй байгуулах нь хамгийн тохиромжтой хэрэгсэл болно.

<sup>25</sup> 21 дүгээр зүүлтийг үзэх.



## **Б. Гэрээлэх арга**

2.44 Гэрээний төрлийг сонгоходоо (i) ажлын шинж чанар, (ii) хамрах хүрээ, гарцыг тодорхойлох боломжтой эсэх, (iii) холбогдох талууд эрсдэлийг хуваан хариуцах зэргийг харгалзан үзнэ.

### **Хугацааны гэрээ<sup>26</sup>**

2.45 Ажлууд өөр хоорондоо хамааралтай, ажил дуусгах хугацаа ялгаатай тул бусад ажлын улмаас үйл ажиллагааг дуусгааа хүлээнэх шалтгаанаар, эсвэл зөвлөхийн орцыг тооцоход хэцүү шалтгаанаар ажлын хамрах хүрээ, гарц, үргэлжлэх хугацааг тодорхойлоход бэрх үед хугацааны гэрээг хэрэглэдэг. Энэ төрлийн гэрээг цогцолбор судалгаа, барилгын хяналт, зөвлөгөө өгөх, сургах ажилд хэрэглэнэ. Төлбөр нь зөвлөхийн орцтой уялдах бөгөөд ихэвчлэн гэрээнд нэрлэгдсэн мэргэжилтний сарын хөлс, бодит зардал, ба/эсвэл тохиролцсон нэгж үнийг ашиглан нөхөн төлөгдөх зардалд үндэслэнэ.

### **Үндсэн цалин ба/эсвэл магадлашгүй ажлын (үр дүнгийн) хөлсний гэрээ**

2.46 Зөвлөхүүд (банк, эсхүл санхүүгийн компаниуд) хувьчлалыг хэрэгжүүлэхийн тулд компанийг худалдах, эсвэл нэгтгэх ажлыг бэлтгэж байгаа тохиолдолд үндсэн цалин ба магадлашгүй ажлын хөлсний гэрээг түгээмэл ашигладаг. Зөвлөхийн цалин хөлс нь үндсэн цалин болон үр дүнгийн хөлсөөс бүрдэх ба үр дүнгийн хөлсийг ихэвчлэн борлуулсан хөрөнгийн үнийн дүнгээс тодорхой хувиар тооцож илэрхийлнэ.

### **Хугацаа нь товлогдоогүй үйлчилгээний гэрээ (Үнийн тохиролцоо)**

2.47 Хэмжээ ба хугацааг урьдчилан тодорхойлох боломжгүй аливаа ажилд зөвлөгөө өгөх “дуудлагын” тусгай үйлчилгээг зээлдэгч авах шаардлагатай үед энэ гэрээг хэрэглэдэг. Ийм гэрээг ихэвчлэн цогцолбор төсөл (жишээ нь, далан барих) хэрэгжүүлэх “зөвлөхүүд”, маргаан шийдвэрлэх багт үйлчлэх мэргэжлийн шүүгч, бүтцийн өөрчлөлт, худалдан авах ажиллагааны зөвлөгөө өгөх, техникийн эвдрэлийг олж засах зэрэг зөвлөхүүдийг гол төлөв нэг жил ба түүнээс дээш хугацаанд бэлэн байлгаж

---

<sup>26</sup> Заримдаа явцын төлбөрийн гэрээ гэж нэрлэдэг.

ажиллуулах тохиолдолд хэрэглэнэ. Зээлдэгч компанитай ажилтны нэгж хөлсийг тохирч, зарцуулсан бодит хугацаанд үндэслэн төлбөрийг хийнэ.

### **Нийт үнийн (НҮ) гэрээ**

2.48 Нийт үнийн гэрээг зөвлөх үйлчилгээний ажлын агуулга, үргэлжлэх хугацаа болон зөвлөхөөс шаардагдах гарц нь тодорхой байдаг ажлуудад хэрэглэдэг. Үүнд энгийн төлөвлөлт, техник эдийн засгийн судалгаа, байгаль орчны үнэлгээ, стандарт эсвэл түгээмэл бүтцийн нарийвчилсан зураг төсөл болон тоо мэдээлэл боловсруулах системийг бэлтгэх гэх мэт ажлууд орно. Гэрээний үнэд бүх зардал багтсан байх ба үнийг тохиролцож үл болно. Төлбөрийг тайлан, ажлын зураг, ажлын тооцоо, ТББ, программ хангамж зэрэг ажлын гарцтай холбож олгоно.

### **Гүйцэтгэлд суурилсан гэрээ**

2.49 Гүйцэтгэлд суурилсан гэрээг зөвлөх үйлчилгээний гарцыг сайжруулж, ингэснээр мөнгөний үнэ цэнийг нэмэгдүүлэх зорилгоор ашигладаг. Төслийн тодорхой үр дүн (жишээ нь төслийн дизайн, мониторингийн хүрээнд тусгагдсан үр дүн эсвэл гарц) гарсан эсэхийг үндэслэн хамгийн чухал гэсэн ажлуудын биелэлтээс хамааран зөвлөхөд төлбөрийг хийнэ. Гэрээний чухал үе шат бүхий ажлуудыг маш сайн зааж өгөх ба үр ашигтай хянаж магадлахад хангалттай тоон үзүүлэлттэй байна. Үе шат бүхий ажил, түүнийг хянах үзүүлэлтүүдийг гэрээний хэлэлцээрийн явцад зөвлөх, эсвэл зээлдэгчтэй тохиролцсоны үндсэн дээр сонгоно. Үе шат бүхий ажлыг хялбар магадлаж болох эсэх нь төслийн шинж агуулгаас хамаарна. Барилгын төслийн хувьд үе шат бүхий ажлыг тодорхойлох нь харьцангуй амар байдаг бол бүтцийг сайжруулах төслийн хувьд нилээд хэцүүхэн байдаг. Хоёр дах тохиолдолд хугацаа болон гүйцэтгэлд суурилсан гэрээний зарчмуудыг хослуулан хэрэглэнэ. Энэ тохиолдолд, зөвлөхийн гэрээний төлбөрийн тодорхой хэсгийг ажилласан хугацаанд, үлдэх хэсгийг гэрээний эцэст ихэвчлэн, стратегийн ач холбогдол бүхий нэг ба хэд хэдэн ажлын гүйцэтгэлийн үр дүнг харгалзан олгоно.

## **В. Зээлийн зөвлөхийн гэрээний чухал заалтууд**

2.50 Гэрээнд дараах зүйлсийг заалт болгон оруулсан байна.

## Мөнгөн тэмдэгт

2.51 Компаниуд үйлчилгээнийхээ үнийг хөрвөх чадвартай мөнгөн тэмдэгтээр илэрхийлэхийг ТББ-т тодорхой тусгасан байна. Хэрэв зөвлөх нь үнийг хэд хэдэн өөр мөнгөн тэмдэгтээр тооцсон дүнгийн нийлбэрээр илэрхийлэхийг хүсвэл, үнийн санал гурваас илүүгүй мөнгөн тэмдэгтийг агуулж болно. Зээлдэгч зөвлөхөөс зарим зардлыг зээлдэгчийн мөнгөн тэмдэгтээр илэрхийлэхийг хүсч болно. Гэрээний төлбөрийг саналд заасан үнийн мөнгөн тэмдэгтээр хийнэ.

## Үнийн тохируулга

2.52 Гэрээт ажил 18 сараас дээш хугацаагаар үргэлжлэх бол цалин хөлсийг гадаад болон дотоодын инфляцийн түвшинд тохируулан өөрчлөх үүднээс үнийн тохируулгын заалтыг гэрээнд тусгаж оруулна. Дотоод эсвэл гадаад инфляц өндөр, урьдчилан таамаглах боломжгүй бол түүнээс богино хугацааны гэрээнд үнийн тохируулгын заалтыг оруулж болно.

## Төлбөрийн заалт

2.53 Үнийн дүн, төлбөрийн хуваарь, төлбөрийн журам зэрэг төлбөрийн заалтуудыг гэрээний хэлэлцээрийн үед тохирно. Төлбөрийг тогтмол хугацаанд (хугацааны гэрээний үед) эсвэл, ажлын гарцад (нийт үнийн гэрээний үед) үндэслэн төлнө. Гэрээний үнийн дүнгийн 10%-иас хэтэрсэн урьдчилгаа төлбөр (жишээ нь, ажил эхлүүлэх зардалд зориулж)-ийг авахдаа ихэвчлэн урьдчилгаа төлбөрийн баталгааг гаргуулна.

2.54 Төлбөрийг гэрээний заалтын дагуу нэн даруй гүйцэтгэнэ. Үүний тулд:

- (а) Зээлдэгчийн хүсэлтээр шууд АХБ-наас, эсвэл аккредитивээр дамжуулан зөвлөхөд төлбөр хийж болно;
- (б) Зөвхөн маргаантай үнийн дүнг саатуулж, нэхэмжлэхийн үлдсэн дүнг гэрээний дагуу төлнө;
- (в) Захиалагчийн буруугаас төлбөрийг гэрээнд заасан хугацаанаас хоцроосон бол ногдуулах мөнгөн торгууль, түүний хувь хэмжээг гэрээнд тусгана.

## Урьдчилгаа төлбөрийн баталгаа

2.55 Зээлийн санхүүжилттэй зөвлөхийн гэрээний хувьд, зээлдэгч нь урьдчилгаа төлбөрийг хийх зорилгоор зөвлөхөөс урьдчилгаа төлбөрийн баталгааг гаргуулж болно.

### Зээлдэгчийн хувь нэмэр

2.56 Зээлдэгч өөрийн ажилтныг янз бүрийн байдлаар ажилд томилон ажиллуулж болно. Зээлдэгч ба зөвлөхийн хооронд байгуулсан гэрээнд зөвлөхтэй хамтран ажиллах ажилтан, түүнчлэн зээлдэгчийн зүгээс гаргах бусад зүйлс, тухайлбал, орон сууц, ажлын байр, нарийн бичгийн үйлчилгээ, ус, дулаан, цахилгаан, материал, унаа тээврийг тусгана. Эдгээрийн аль нэгийг гаргаагүй, эсвэл ажлын явцад тэдгээрийг эргүүлэн татах тохиолдолд зөвлөхийн авч болох арга хэмжээ, зөвлөхөд өгч болох нөхөн төлбөрийн талаар гэрээнд заана.

### Сонирхлын зөрчил

2.57 Аливаа этгээд албан үүрэг, хариуцлагаа гүйцэтгэх, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, эсхүл холбогдох хууль тогтоомж, журмыг мөрдөхөд зүй бусаар нөлөөлөхүйц сонирхолтой байх, мөн уг сонирхлын зөрчил нь АХБ-ны авлигын эсрэг бодлогод хориглосон үйлдлийг бий болгох, эсвэл бий болгоход нөлөөлөх тийм тохиолдлыг АХБ сонирхлын зөрчил гэж үздэг. Авлигын эсрэг бодлого нь зээлдэгчийг (АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагааны үр шим хүртэгчид) төдийгүй АХБ-ны санхүүжилттэй гэрээний зөвлөхүүдийг ёс зүйн дээд хэм хэмжээг баримтлахыг шаарддаг. Хэрэв сонирхлын зөрчлийн улмаас зөвлөх сонгон шалгаруулах үйл явц шударга бус явагдсан нь тогтоогдвол АХБ ийм сонирхлын зөрчлийг зохицуулах арга хэмжээ авах бөгөөд гэрээний эрх олгох саналаас татгалзаж болно. Энэхүү журмын 1.11 дүгээр зүйлд заасан шаардлагын дагуу компанийн зөвлөх үйлчилгээнээс үүдэн гарсан, эсхүл шууд холбоотой өөр ажлуудад тухайн зөвлөхийг цаашид ажиллуулахыг хязгаарласан заалтыг гэрээнд тусгана.

## **Мэргэжлийн хариуцлага**

2.58 Зөвлөх нь ажлыг мөрдөгдөж буй мэргэжлийн стандартын дагуу хичээнгүйлэн гүйцэтгэх үүрэгтэй. Зээлдэгчийн өмнө зөвлөхийн хүлээх хариуцлагыг холбогдох хуулиар зохицуулах тул талууд энэ хариуцлагыг хязгаарлахаас бусад тохиолдолд гэрээнд энэ асуудлыг тусгайлан оруулах шаардлагагүй. Хэрэв талууд энэ асуудлыг тусгаж оруулах бол (а) зөвлөх хайхрамжгүй байдлаар алдаа гаргасан, эсвэл санаатайгаар буруу үйлдэлд хийсэн тохиолдолд хязгаарлалт тавихгүй; (б) зээлдэгчийн өмнө зөвлөхийн хүлээх хариуцлагыг ямар ч тохиолдолд ТББ, гэрээний тусгай нөхцөлд заасан гэрээний нийт үнийн үржүүлэгчээс багагүй байхаар хязгаарлана (ийм хязгаарлалтын хэмжээ тухайн нөхцлөөс хамаарна); (в) ийм хязгаарлалт зөвхөн зээлдэгчийн өмнө зөвлөхийн хүлээх хариуцлагад хамаарах бөгөөд гуравдагч этгээдийн өмнө зөвлөхийн хүлээх хариуцлагад үл хамаарах зэргийг эхлээд шалгаж үзэх ёстой.

## **Мэргэжилтнийг солих**

2.59 Ажлын явцад хэрэв мэргэжилтнийг солих шаардлагатай бол (жишээ нь, эрүүл мэнд муудах, нас барах эсвэл ажилд тохирохгүй болох нь нотлогдвол) зөвлөх наад зах нь ижил түвшний ур чадвар бүхий өөр ажилтныг зээлдэгчээс зөвшөөрөл авахаар санал болгоно.

## **Мөрдөх хууль ба маргааныг шийдвэрлэх**

2.60 Гэрээнд мөрдөгдөх хууль, маргааныг шийдвэрлэх арга замын тухай заалтыг оруулна. Зөвлөхийн гэрээнд маргааныг шийдвэрлэх заалтыг заавал оруулна. Олон улсын худалдааны арбитр нь маргаан шийдвэрлэх үед хэрэглэх бусад аргуудаас илүү практик давуу талтай байдаг. Иймд зээлдэгч ийм төрлийн арбитрыг дурдаж өгөх нь зүйтэй. АХБ-ыг арбитрчээр томилон нэрлэхгүй, эсхүл арбитрчийг тодорхойлж өгөхийг АХБ-наас хүсч үл болно.

## **Г. Хяналт тавих ба гүйцэтгэлийг үнэлэх**

### **Сонгон шалгаруулах явцыг хянах**

2.61 АХБ зээлийн ба ТТ-ны төсөлд зөвлөхийг ажилд авах үйл ажиллагааг хянах (ЗАҮХ) маягт хэмээх хяналтын хэрэгслийг ашигладаг. Энэ нь ажилд авах үйл явцыг хэд хэдэн үйл ажиллагаанд хувааж, үйл ажиллагаа бүрийг

болон нийт үйл явцыг дуусгах зорилтот хугацааг тогтоох үүднээс “норм хэмжээ” (ажлын өдөр)-г тогтооно. Мөн ЗАУХ маягт нь (i) үйл ажиллагааг хэрэгжүүлэх, (ii) бодит хугацааг зорилтот хугацаатай харьцуулан хянах, ба шаардлагатай бол (iii) цаг тухайд нь арга хэмжээ авах зэрэгтэй холбоотой этгээдийн үүрэг хариуцлагыг тодорхойлж өгнө. ЗАУХ маягтыг сонгон шалгаруулах бүх арга ба техникийн саналд хэрэглэж болно.

### **Гүйцэтгэлийн үнэлгээ**

2.62 Зээлдэгч зээл ба шилжүүлсэн ТТ-ны зөвлөх компани, зөвлөх хувь хүний ажлын гүйцэтгэлийг үнэлнэ. АХБ зээлдэгчтэй зөвлөлдсөний дагуу ТТ-ны зөвлөхийн ажлын гүйцэтгэлийг үнэлнэ. Ажлын хугацаанаас хамааран үнэлгээг ажлын явцад эсхүл дуусах үед хийж болно. Зөвлөх ажлын дараах асуулгаар дамжуулан, үнэлгээний тайлан, түүнчлэн зээлдэгч ба АХБ-ны ажлын гүйцэтгэлд саналаа өгөх боломжтой. Гэрээний хэлэлцээний үеэр зээлдэгч эсхүл АХБ хэлэлцээ хийж буй зөвлөхөд гүйцэтгэлийн үнэлгээний маягтын хуулбар, зөвлөхийн бөглөх ажлын дараах асуулгыг өгч, гүйцэтгэлийн үнэлгээний тайланг гаргах болон ажлын дараах асуулгыг бөглөх зааврыг тайлбарлана. Ажил дуусмагц зээлдэгч эсхүл АХБ нийт үнэлгээ, ялангуяа хангалтгүй үнэлгээг тайлбарласан нууц тайланг бэлтгэнэ. Хэрэв хожим нь компанийн гүйцэтгэл маш хангалтгүй болох нь батлагдвал энэ тайланг аливаа хязгаарлалт эсвэл хоригт ашиглаж болно. Гүйцэтгэлийн үнэлгээний, түүнчлэн зээлдэгч эсхүл АХБ-ны гүйцэтгэлийн талаарх дүгнэлтэд санал өгөх боломжийг зөвлөхөд олгоно. АХБ зөвлөх компани, зөвлөх хувь хүний гүйцэтгэлийн талаар архив бүрдүүлж, энэ бүртгэлийг ТТ, зээлийн зөвлөхийн хураангуй жагсаалт гаргах үед шалгана.

# 1 дүгээр хавсралт

## Чанар ба үнэд суурилсан сонгон шалгаруулалт (ЧҮСС) ба Чанарт суурилсан сонгон шалгаруулалт (ЧСС)-ын журмын хураангуй дүгнэлт

### Хүснэгт А1: ЧҮСС-ын горим

№	Зээл ба Шилжүүлсэн ТТ-ны төсөл	ТТ-ны төсөл
(i)	АД ба төсөвт өртгийг боловсруулах	АД ба төсөвт өртгийг боловсруулах
(ii)	Зарлан мэдээлэх	Зарлан мэдээлэх
(iii)	Зөвлөхийн дэлгэрэнгүй жагсаалт гаргах	Зөвлөхийн дэлгэрэнгүй жагсаалт гаргах
(iv)	ТББ, зөвлөхийн хураангуй жагсаалт бэлтгэх	ТББ, зөвлөхийн хураангуй жагсаалт бэлтгэх
АХБ руу эхний материалыг явуулах <sup>a</sup>		
(v)	ТББ-ийг тараах	ТББ-ийг тараах
(vi)	Санал хүлээн авах	Санал хүлээн авах
(vii)	Техникийн саналыг үнэлэх	Техникийн саналыг үнэлэх
АХБ руу хоёр дах материалыг явуулах		
(viii)	Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээх	Санхүүгийн саналыг нийтийн өмнө нээх
(ix)	Санхүүгийн саналыг үнэлэх	Санхүүгийн саналыг үнэлэх
(x)	Саналыг эрэмбэлэх	Саналыг эрэмбэлэх
АХБ руу гурав дах материалыг явуулах <sup>a</sup>		
(xi)	Гарын үсэг зурсан гэрээний хуулбарыг АХБ руу илгээх	Хэлэлцээ хийх, гэрээнд гарын үсэг зурах
(xii)	Гэрээ байгуулах эрх олгосон тухай нийтэд мэдээлэх	Гэрээ байгуулах эрх олгосон тухай нийтэд мэдээлэх
(xiii)	Тайлбар өгөх	Тайлбар өгөх

АХБ = Азийн Хөгжлийн Банк, ЧСС = чанарт суурилсан сонгон шалгаруулалт, ЧҮСС = чанар ба үнэд суурилсан сонгон шалгаруулалт, ТББ = тендерийн баримт бичиг, ТТ = техникийн туслалцаа, АД = ажлын даалгавар.

<sup>a</sup> Сонгон шалгаруулах чадавхтай нь батлагдсан гүйцэтгэгч агентлагууд (1.27, 2.3 дугаар зүйлийг үз). Эх үүсвэр: АХБ-ны тооцоо.

## Хүснэгт А2: ЧСС-ын горим

№	Зээл ба Шилжүүлсэн ТТ-ны төсөл	ТТ-ны төсөл
(i)	АД боловсруулах	АД боловсруулах
(ii)	Зарлан мэдээлэх	Зарлан мэдээлэх
(iii)	Зөвлөхийн дэлгэрэнгүй жагсаалт гаргах	Зөвлөхийн дэлгэрэнгүй жагсаалт гаргах
(iv)	ТББ, зөвлөхийн хураангуй жагсаалт бэлтгэх	ТББ, зөвлөхийн хураангуй жагсаалт бэлтгэх
АХБ руу эхний материалыг явуулах		
(v)	ТББ-ийг тараах	ТББ-ийг тараах
(vi)	Санал хүлээн авах	Санал хүлээн авах
(vii)	Техникийн саналыг үнэлэх, эрэмбэлэх	Техникийн саналыг үнэлэх, эрэмбэлэх
АХБ руу хоёр дах материалыг явуулах		
(viii)	Зээлдэгч техникийн саналаар хамгийн өндөр оноо авсан зөвлөхөөс санхүүгийн санал ирүүлэхийг хүсэх	АХБ техникийн саналаар хамгийн өндөр оноо авсан зөвлөхөөс санхүүгийн санал ирүүлэхийг хүсэх
(ix)	Шалгарсан компанитай хэлэлцээ хийж, гэрээний төслийг бэлтгэх	Шалгарсан компанитай хэлэлцээ хийх
(x)	Гэрээнд гарын үсэг зурах	Гэрээнд гарын үсэг зурах
(xi)	Гарын үсэг зурсан гэрээний хуулбарыг АХБ руу явуулах	
(xii)	Гэрээ байгуулах эрх олгосон тухай нийтэд мэдээлэх	Гэрээ байгуулах эрх олгосон тухай нийтэд мэдээлэх

АХБ = Азийн Хөгжлийн Банк, ЧСС = чанарт суурилсан сонгон шалгаруулалт, ТББ = тендерийн баримт бичиг, ТТ = техникийн туслалцаа, АД = ажлын даалгавар.  
Эх үүсвэр: АХБ-ны тооцоо.



## 2 дугаар хавсралт

### Зээлийн төслийн зөвлөхөд зориулсан заавар

#### Зорилго

1.1 Энэхүү хавсралтад Азийн Хөгжлийн Банк (АХБ)-ны санхүүжилттэй болон АХБ-наас захиран зарцуулдаг сангийн санхүүжилттэй зээлийн төслийн хүрээнд зөвлөх үйлчилгээ үзүүлэхийг хүсч байгаа зөвлөхүүдэд өгөх зааврыг багтаав.

#### Зөвлөхийг сонгон шалгаруулах үүрэг, хариуцлага

- 1.2 (i) Зээлийн төслийн тухайд зээлдэгч нь төслийг хэрэгжүүлэх, төслийн зөвлөх үйлчилгээний төлбөр хийх үүрэг хариуцлагыг дангаараа хариуцна. АХБ зөвхөн гарсан зардлыг зээлийн хөрөнгөнөөс санхүүжүүлэн төлсөн эсэхийг баталгаажуулах үүрэгтэй.
- (ii) Зөвхөн зээлдэгчийн хүсэлтийн дагуу зээлийн хөрөнгийг зарцуулна. Зээлийн хэлэлцээрт заасны дагуу хөрөнгийг ашигласан болохыг нотлох баримтыг данс зузаатгах тухай зээлдэгчийн өргөдлийн хамт илгээнэ. Төлбөрийг (а) зээлдэгч өөрийн хөрөнгөнөөс нэгэнт хийсэн төлбөрийг түүнд нөхөн санхүүжүүлэхэд, эсхүл (б) шууд гуравдагч талд (тухайлбал, зөвлөхөд) шилжүүлж болно.
- (iii) Энэхүү журамд заасанчлан зээлдэгч зээлийн зөвлөхийг ажилд авах үүрэгтэй. Зээлдэгч сонгон шалгаруулалтад урьж, саналыг хүлээн авч үнэлэн, гэрээ байгуулах эрхийг олгоно. Гэрээг зээлдэгч, зөвлөхийн хооронд байгуулна. АХБ гэрээний тал болж оролцохгүй.

#### АХБ-ны үүрэг

- 1.3 (i) Энэхүү журамд заасанчлан, АХБ тендерийн баримт бичиг (ТББ), хураангуй жагсаалт, техникийн саналын үнэлгээ, гэрээ байгуулах эрх олгох санал болон гэрээ зэрэг материалыг зээлийн хэлэлцээр, худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд

шаардсан хүрээнд харилцан тохиролцсон горимын дагуу явагдсан эсэхийг баталгаажуулахын үүднээс хянана. Урьдчилан хянах шаардлагатай бүх гэрээний хувьд, АХБ зээлдэгчээс ирүүлсэн материалыг уг материалыг тараахын өмнө нягталж шалгана.

- (ii) Сонгон шалгаруулалтын аль ч шатанд (гэрээ байгуулах эрх олгосны дараа ч гэсэн) харилцан тохиролцсон журмаа ихээхэн мөрдөөгүй гэж АХБ дүгнэвэл энэхүү журмын 1.18 дугаар зүйлд заасны дагуу АХБ худалдан авах ажиллагааг хүчингүйд тооцож мэдэгдэнэ. Гэхдээ, хэрэв зээлдэгч АХБ-наас зөвшөөрөл авснаас хойш гэрээний эрх олгосон бол, зөвхөн зээлдэгчээс ирүүлсэн бүрэн бус, алдаатай, төөрөгдүүлсэн мэдээллийн дагуу зөвшөөрсөн тохиолдолд АХБ зүй бус худалдан авах ажиллагаа хэмээн зарлана.
- (iii) Түүнээс гадна, хэрэв зээлдэгчийн, эсхүл зөвлөхийн төлөөлөгч авлига, залилан мэхлэх, үгсэн хуйвалдах, дарамт шахалт үзүүлэх, бусад хориглосон үйлдэлд оролцсон гэж АХБ үзвэл энэ журмын 1.23(г) дугаар зүйлд заасны дагуу зохих хоригийг тогтооно.
- (iv) АХБ төрөл бүрийн зөвлөх үйлчилгээний жишиг ТББ ба гэрээг бэлтгэн гаргадаг. Зээлдэгч эдгээр баримт бичгүүдийг заавал хэрэглэх шаардлагатай ба төслийн өвөрмөц онцлогоос хамааран бага зэрэг өөрчлөлтийг АХБ-ны зөвшөөрөлтэйгөөр оруулж болно. Зээлдэгч ТББ-ын нэг хэсгийн хувьд эдгээр баримт бичгүүдийг эцэслэн боловсруулж, тараана.

## **Зөвлөх үйлчилгээний тухай мэдээлэл**

- 1.4 (i) Үйлчилгээний шинж чанарын тухай товч танилцуулга, үргэлжлэх хугацаа, төсөвт өртөг, хүн-сар зэрэг зөвлөх үйлчилгээний мэдээллийг эхний ээлжинд хураангуй жагсаалтыг гаргахаас 30-аас доошгүй хоногийн өмнө АХБ-ны вэб хуудсанд нийтлэнэ.
- (ii) ТТ-ны болон зээлийн зөвлөхийн гэрээний эрхийг олгосны дараа, АХБ вэб хуудсанд (а) санал ирүүлсэн бүх зөвлөхийн нэр, (б) зөвлөх бүрт өгсөн техникийн оноо, (в) зөвлөхийн нийт эрэмбэлэл, (г) шалгарсан зөвлөхийн нэр, гэрээний үнэ, үргэлжлэх хугацаа, гэрээний товч агуулга зэрэг мэдээллийг байршуулна.

## Зөвлөхийн үүрэг

- 1.5 (i) Зөвлөхүүд ТББ-ыг авах үед, хэрэв АД-ын шаардлага, арилжааны ба гэрээний нөхцлийг хангаж байвал шаардлагад нийцсэн санал бэлтгэхэд шаардлагатай арга хэмжээг авна (жишээ нь, ажил хийх оронд айлчлан танилцах, хамтрах байгууллагыг эрж хайх, баримт бичиг цуглуулах, ажилд бэлтгэх баг бүрдүүлэх). Хэрэв зөвлөх ТББ-т, ялангуяа сонгон шалгаруулах горим, үнэлгээний шалгуур үзүүлэлтэд хоёрдмол утга санаа, орхисон зүйл, хоорондын зөрчил, ойлгомжгүй, ялгаварласан, эсвэл хязгаарласан шинжтэй заалт байна гэж үзвэл, ТББ-т заасан тодруулга хийх хугацаанд багтаан зээлдэгчээс тодруулгыг бичгээр хүсч болно. Үүнтэй уялдан, зээлдэгчийн боловсруулсан ТББ нь тухайн сонгон шалгаруулалт бүрийг зохицуулна гэдгийг дурдах нь зүйтэй. Хэрэв ТББ-ын аль нэг заалт энэхүү журамтай нийцэхгүй байна гэж зөвлөх үзвэл энэ асуудлыг түүнчлэн зээлдэгчид тавина.
- (ii) Зөвлөх шаардлагад бүрэн нийцсэн саналыг ТББ-т шаардсан бүх баримтын хамт ирүүлэх үүрэгтэй. Тендерийн саналтай хамт ирүүлсэн ажилтнуудын анкет үнэн зөв эсэхийг заавал нягтлах хэрэгтэй. Анкет агуулгын хувьд үнэн зөв, ажилтнуудын бэлэн байгаа эсэхийг баталгаажуулан анкетад гарын үсэг зурж огноог бичсэн байна. Нэн чухал шаардлагуудыг хангаагүй бол саналаас татгалзаж болно. Техникийн саналыг нэгэнт хүлээн авч нээсэн л бол саналын үндсэн хэсэг, ажилтнууд, бусад зүйлийг зөвлөхүүд өөрчлөхийг зөвшөөрөхгүй. Үүнтэй нэгэн адилаар, санхүүгийн саналыг хүлээн авснаас хойш, ТББ-т заасны дагуу хэлэлцээ хийхээс бусад нөхцөлд санал болгосон үнэ ба бусад зүйлийг өөрчлөхийг үл зөвшөөрнө. Хэрэв саналын хүчинтэй хугацааг сунгасны улмаас ажилтнууд ажиллах боломжгүйд хүрвэл, түүнтэй дүйцэхүйц эсхүл илүү чадавхитай өөр ажилтнаар сольж болно.

## Нууцлал

- 1.6 2.13 дугаар зүйлд заасны дагуу техникийн оноог нийтэд зарлах, 2.14 дүгээр зүйлд заасны дагуу санхүүгийн саналыг нийтийн өмнө нээх үед санхүүгийн мэдээллийг зарлахаас бусад тохиолдолд, энэ журмын 2.21 дүгээр зүйлд заасны дагуу гэрээний эрхийг зарлах хүртэл санал үнэлэх

явцыг нууцлана. Ийнхүү нууцлах нь зүй бусаар оролцох бодит байдал, эсвэл оролцох ойлголт төрүүлэхээс сэргийлэх боломжийг зээлдэгч ба АХБ-ны хянагч нарт олгодог.

### **Ажилд авах явцад гарах гомдол**

1.7 Хэрэв ажилд авах явцад, зөвлөх нь сонгон шалгаруулалт шударга явагдаж байгаа эсэх талаар зээлдэгч, АХБ эсвэл хоёуланд нь мэдээлэхийг хүсвэл, зээлдэгчээр дамжуулан бичгээр мэдэгдэх эсхүл зээлдэгч даруй хариулаагүй эсхүл зээлдэгчийн талаар гомдол гаргах бол АХБ руу шууд бичгээр хандаж болно.

### **Гэрээний эрх олгосны дараа тайлбар хүсэх**

1.8 Хэрэв гэрээний эрх олгосны дараа, зөвлөх нь түүний санал шалгарч чадаагүй үндэслэлийг мэдэхийг хүсвэл зээлдэгчид хүсэлтээ гаргаж болно. Хэрэв зөвлөх тайлбарыг хангалтгүй гэж үзвэл АХБ руу шууд бичгээр хандаж болно.



## Азийн Хөгжлийн Банкны тухай

АХБ-ны алсын хараа нь Ази, Номхон далайн орнуудыг ядуурлаас ангижруулах явдал бөгөөд үйл ажиллагааны гол зорилго нь хөгжиж буй гишүүн орнуудын ядуурлыг бууруулах, хүн амын амьжиргааны түвшинг дээшлүүлэхэд чиглэгддэг. Бүс нутгийн хувьд ахиц амжилтаар баялаг хэдий ч дэлхийн нийт ядуу иргэдийн гуравны хоёр нь энэхүү бүс нутагт амьдарч байгаагаас 1.7 тэрбум хүн өдөрт 2 ам.доллараас бага өртгөөр, харин 828 сая иргэд 1.25 ам.доллараас бага өртгөөр амь зууж байна. АХБ нь олныг хамарсан өргөн хүрээтэй эдийн засгийн өсөлт, байгаль орчны тогтвортой өсөлт болон бүс нутгийн хамтын ажиллагааг хангах замаар ядуурлыг бууруулахын төлөө ажилладаг юм.

Манила хотод төвтэй АХБ нь нийт 67 гишүүн оронтой бөгөөд үүнээс 48 нь энэхүү бүс нутагт оршдог. АХБ нь бодлогын хэлэлцүүлэг, зээл, хөрөнгө оруулалтын хувьцаа, баталгаа, буцалтгүй тусламж болон техникийн туслалцаа зэрэг хэрэгслээр дамжуулан хөгжиж буй гишүүн орнууддаа дэмжлэг үзүүлдэг.

Азийн Хөгжлийн Банк  
6 АХБ-ны өргөн чөлөө, Мандалуён хот  
1550 Метро Манила, Филиппин улс  
[www.adb.org](http://www.adb.org)